



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2013 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 1/48

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны хангалтын үр нөлөөт байдал"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Нийцлийн аудитын тайланг аймгийн ИТХ, Төрийн албаны зөвлөл, Төрийн албаны салбар зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн, арга хэмжээ авч үр дүнг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Г.Төмөрбаатар, МХГ-ын дарга Д.Лхагвасүрэн, Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Тус аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, Гүйцэтгэлийн аудитын багийн ахлагч, ахлах аудитор /Л.Энх-Амгалан/ нарт даалгасугай.

ЕРӨНХИЙ АУДИТОР

Г.ОЮУНГЭРЭЛ

My.Doc. Tushaal
0_102

Ерөнхий аудиторын 2013 оны 12 дугаар сарын

17-ны өдрийн 1/4 тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн /мян.төг/
	Нэр	Албан тушаал			
1	В.Баяраа	Аймгийн татварын хэлтсийн дарга	Зөрчил арилгуулах тухай	01/39	-
2	Г.Төмөрбаатар	Аймгийн ЗДТГ-ын дарга	Зөрчил арилгуулах тухай	01/40	-
3	Г.Төмөрбаатар	Аймгийн ТАСЗ-ийн дарга	Төсөвт төвлөрүүлэх тухай	01/27	1.022.3
4	Ц.Жамсранжав	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга	Төсөвт төвлөрүүлэх тухай	01/28	9.826.1
5	Г.Төмөрбаатар	Аймгийн ЗДТГ-ын дарга	Төсөвт төвлөрүүлэх тухай	01/29	4.264.2

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн захиргааны албан хаагчдын ажлын
байрны хангалтын үр нөлөөт байдал

ХөААГ – ГА/2013/12-НА

*Аймгийн Аудитын газрын төлөвлөгөө удирдамжийн дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан.*



**ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БАШИР
АРГААР ТӨРИЙН АЛБА ТАНИЛЫН АЛБА БОЛСОН
БАЙНА.**

2013 оны 12 дугаар сар

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	5
ААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг 2	Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	6-7
Ерөнхий аудитор: Г.Оюунгэрэл Утас: 96665871	Нэг дүгээр бүлэг. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРООГҮЙ ИРГЭН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДСОН БАЙНА.	8-9
Аудитын менежер: Г.Эрдэнэчимэг Утас: 99016320	1.1. Танилтай бол төрийн албанд ажиллахад бэлэн болжээ.	9-15
Ахлах аудитор: Л. Энх-Амгалан Утас: 96383478	1.2. Түр тушаалтай иргэнийг тангараг өргүүлж байгаа нь төрийн албаны нэр хүнд алдагдахад хүргэж байна.	15-17
Шинжээч: Н.Бямбадорж Утас: 98116756	1.3. Тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан тушаалтныг ажлаас халах нь эрх бүхий албан тушаалтны дурын асуудал болсон байна.	17-19
	1.4. Ажлаас чөлөөлөгдсөн иргэдэд 6 сарын тэтгэмжийг үндэслэлгүй олгож байна.	19-20
	1.5. Аймгийн Засаг дарга бусдын ажилд хутгалдаж байна.	20-22
2013 оны 12 дугаар сар	1.6. Төрийн чиг үүргийг хамаарал бүхий этгээдүүд гүйцэтгэх сонирхолтой байна.	22-22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?	I бүлгийн дүгнэлт	23
Khuvsgul.audit@yahoo.com Facebook.com/khuvsgulaudit	Хоёр дугаар бүлэг. АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ ЧИГ ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.	25
	2.1. Төрийн албаны мэргэшлийн шалгалт цахим хэлбэрт шилжсэн нь шалгуулагчдаас хурд, техник хэрэглээ, бэлтгэлийг шаардах болсон байна.	25-29
	2.2. Сул орон тоог мэдээлэх явц иргэдийг төөрөгдүүлж байна.	29-30
	2.3. Ажил олгогч нь нөөцийн бүртгэлээс шалгуур хангасан иргэнийг сонгож авахад хүндрэлтэй байна.	30-36
	2.4. Зэрэг дэвийн үнэ цэнийг алдагдуулсан байна	36-37
	2.5. Эрх бүхий албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, томилгоотой холбоотой өргөдөл, гомдол гаргасан иргэд цөөнгүй байна.	37-39
	2.6. Шалгуулагчдаас хураан авч буй мөнгөн төлбөрийн зарцуулалт хяналтгүй байна.	39-42
	II бүлгийн дүгнэлт	42
	Зөвлөмж:	42-44
	Холбогдох байгууллагын санал:	45-48
	Хавсралт	49-55

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГАБ	Гүйцэтгэлийн аудитын баг
ГА	Гүйцэтгэлийн аудит
НА	Нийцлийн аудит
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАХ	Төрийн албан хаагч
ТЖАХ	Төрийн жинхэнэ албан хаагч
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТС	Санхүү төрийн сан
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ХШҮТ	Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг
ХХААЖДҮГ	Хүнс,Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
БСГ	Боловсрол, соёлын газар
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
ХХҮХ	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОХ	Байгал орчны хяналт
ДАЭСС	Дотоод ажил, эрх зүй, сургалт сурталчилгаа
МАА	Мал аж ахуй
ТАМШ	Төрийн албаны мэргэшлийн шалгалт
ТББ	Төрийн бус байгууллага

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Аудитыг аймгийн Ерөнхий аудиторт гүйцэтгэлийн аудитын 2 дугаар багаас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны хангалтын үр нөлөөт байдал” нийцлийн аудит хийв.

Аудитын зорилт

Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн болон төрийн захиргааны албанд ажлын байрны тодорхойлолтод нийцсэн, тусгай болон ерөнхий шаардлагыг хангасан төрийн албан хаагч ажиллаж байгаа эсэхийг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Үүнд:

- Батлагдсан орон тоо, ажлын байрны тодорхойлолтод нийцсэн төрийн албан хаагчид ажиллаж байна уу?
- ТАСЗөвлөл нь үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна уу?

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад төлөвлөлтийн явцад эрсдэл өндөртэй гэж тогтоогдсон төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын байрны хангалт, хувийн хэрэг хөтлөлт, сонгон шалгаруулалт, төрийн удирдах болон жинхэнэ албан хаагчид ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагад нийцэж байгаа эсэх, Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа, Аймгийн ЗДТГазар, Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлагуудын 2009-2012 он, 2013 оны эхний хагас жилийн баримт материал, Мөрөн, Арбулаг, Төмөрбулаг, Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох зэрэг сумдын ИТХ, ЗДТГ-ыг хамруулан бусад сумдаас ирүүлсэн 2011-2013 онуудад томилогдсон төрийн захиргааны албан хаагчдын судалгаанд үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн нууцын тухай хууль

- МУ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”
- Монгол улсын Засгийн газрын 2012 оны 78 дугаар тогтоол
- Монгол улсын Засгийн газрын 2007 оны 354 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”
- ТАЗ-ийн 2009 оны 99-р тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”
- ТАЗ-ийн 2009 оны 126 дугаар тогтоол “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай”
- ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай”
- ТАЗ-ийн 2009 оны 63 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай”
- ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай”
- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд


Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны хангалт, тэдгээрийн төрийн албаны ерөнхий болон тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх, ТАСЗ-ийн үйл ажиллагааний талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулж, түүнд дүн шинжилгээг хийн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Ерөнхий аудитор Г.Оюунгэрэл удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймгийн Аудитын газрын гүйцэтгэлийн аудитын 2 дугаар багийн ахлах аудитор Л.Энх-Амгалан, шинжээч Н.Бямбадорж нар гүйцэтгэв.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймаг нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 23 сум 1 тосгонтой 127000 гаруй хүн амтай бөгөөд нийт 6100 төрийн албан хаагч үүнээс 603 төрийн захиргааны албан хаагч ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолоор тогтоосон аймгийн ЗДТГ-ын бүтцийн дагуу орон тооны хязгаарт багтааж, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог зөвшилцөх тухай” аймгийн Засаг даргын 2008 оны 345 дугаар захирамж гарч, хэлтсүүдэд байх орон тоо, албан тушаалыг шинэчлэн баталж мөрдүүлэн ажиллах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр аймгийн ЗДТГ нь 5 хэлтэс, 2 тасаг, 1 штабтай тэдгээрт нийт 43 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалаар үндсэн бүтцийн нэгжийн дарга, мэргэжилтнүүдийг чөлөөлж мөн мөн өдрийн 101 дүгээр тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 27.2.3, 27.2.4, Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 345 дугаар захирамжийг тус тус үндэслэн дарга, мэргэжилтнүүдийг томилсон байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны А/376, 2011 оны А/409 дүгээр захирамжуудаар сумдын ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн тогтоон, бүтэц, орон тоог батлан мөрдүүлж байна.

Аймгийн ТАСЗөвлөл нь ТА3-ийн 2009 оны 02 дугаар сарын 19-ний 23 дугаар тогтоол, 2013 оны 07 дугаар сарын 10-ны 141 дүгээр тогтоолоор тус тус баталсан 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Монгол улсын засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 129 дүгээр тогтоол зэргийг үндэслэн аймгийн төрийн албан хаагчдын ёс зүйн хороог аймгийн ЗДТГ-ын даргын 2011 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулсан байна.

Аймгийн Төрийн албан хаагчдын ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд:

Ёс зүйн хорооны дарга-Г.Гандэлгэр /АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга/

Нарийн бичгийн дарга-Л.Бямбасүрэн /АЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн /

Гишүүнээр: С.Энхзаяа-АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн

Сүүлийн 5 жилийн байдлаар төрийн жинхэнэ албанд анх орох иргэний төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 10 удаа зохион байгуулж, нийт 196 ажлын байранд 1352 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдсэнээс, 304 иргэн зарлагдсан ажлын байранд томилогдсон мэдээлэл байна. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 27 ажлын байранд нийт 6 удаа зохион байгуулсан байна.

1.1. Танилтай бол төрийн албанд ажиллахад бэлэн болжээ.

Тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх гэх ерөнхий шаардлагыг хангаагүй иргэнийг төрийн албанд томилох, ажлын байрны тодорхойлолтгүй төрийн албан хаагчид ажиллаж байгаа нь төрийн албаны стандарт алдагдахаас гадна төрийн албаны томилгоонд танил тал ихээхэн үүрэг гүйцэтгэснийг харуулж байна. **Тухайлбал:**

✚ “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 21.2¹, “Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм”² зэрэгт зааснаар нягтлан бодох бүртгэл, аудит дотоод хяналтын ажлыг бодлогоор удирдаж, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг чанаржуулж арга зүйн удирдлагаар хангах зэрэг чиг үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь *улсын байцаагч байх ба улсын байцаагч мэргэшсэн нягтлан бодогч байх шаардлагатай байна*. Гэтэл дээрх чиг үүрэг бүхий нягтлан бодох бүртгэл, аудитын бодлого хариуцсан мэргэжилтнээр Төмөрбулаг сумын засаг даргаар ажиллаж байсан Т.Энхтуяаг “мэргэшсэн нягтлан бодогч”-ийн эрхгүй, ажлын байранд тавигдах шаардлагад нийцэхгүй байсаар байтал уг албан тушаалд томилж тангараг өргүүлсэн байна. Аудитын хугацаанд уг ажлын байран дахь шаардлагын талаар Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд хүсэлт гаргасны дагуу Сангийн Яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 13-ны 6/6198 тоот албан бичигт “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд бүртгэлийн мэргэжилтэн заавал мэргэшсэн нягтлан бодогч байна гэсэн шаардлага, шалгуур байхгүй учраас тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар мэргэжлийн нягтлан бодогчоор тухайн ажлыг гүйцэтгүүлж болно” гэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 21.2 дэх заалт,

¹ 21.2-д Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий, ахлах болон улсын байцаагч нь мэргэшсэн нягтлан бодогч байна

² 5.Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ... улсын байцаагч байна.

8. Ахлах байцаагч, улсын байцаагч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч байна.

Хүснэгт №2

№	Овог нэр	Албан тушаал	Сонгон шалгаруулалтанд орсон ажлын байр
1	Г.Цэнд-Аюуш	Аймгийн ГХБХБГазрын дарга	Рашаант сумын ЗДТГ-ын даргын сонгон шалгаруулалтанд орж ТАС3-ийн 2009 оны 12 дугаар сарын 17-ны 26 дугаар тогтоолоор баталгаажсан.
2	Б.Эрдэнэбилэг	Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга	Баянзүрх сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтанд орж нөөцөд бүртгэгдсэн. / 2011 оны 6-р сар/
3	Б.Болд	Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга	Тариалан сумын ЗДТГ-ын даргын сонгон шалгаруулалтанд орж нөөцөд бүртгэгдсэн
4	Б.Галбадрах	Аймгийн ХХААЖДҮГазрын дарга	Ханх сумын ЗДТГ-ын даргын сонгон шалгаруулалтанд орж нөөцөд бүртгэгдсэн. / 2011 оны 6-р сар/
5	Г.Нэргүй	Мөрөн сумын ЗДТГ-ын дарга	Цэцэрлэг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтанд орж нөөцөд бүртгэгдсэн.

Хүснэгтээс харахад: Аймгийн ГХБХБГазрын дарга Г.Цэнд-Аюуш, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга Б.Болд, ХХААЖДҮГазрын дарга Б.Галбадрах, Мөрөн сумын ЗДТГ-ын дарга Г.Нэргүй нар сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын болон ЗДТГ-ын даргын ажлын байрны сонгон шалгаруулалтанд орж нөөцөөс томилогдсон байна.

- Аймгийн засаг даргын 2009 оны 4 дүгээр сарын 13-ны 98 дугаар захирамжаар томилогдсон Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Ч.Уртнасан тухайн ажлын байрны сонгон шалгаруулалтанд ороогүй байна.

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2010 оны 5 дугаар сарын 10-ны Б/18 тоот тушаалаар Хууль зүйн хэлтсийн даргаар Г.Гандэлгэрийг, 2008 оны 12-дугаар сарын 31-ны 101 тоот тушаалаар ХБХэлтсийн даргаар Х.Ган-Очирыг тус тус томилсон байна. УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын дээр дурьдсан 40-р заалт болон 14-ийн а/Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, төрийн жинхэнэ албан тушаалд бэлтгэгдсэн байдал, мэргэшлийн түвшингээр нь 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж, ТАЗ буюу ТАС3-ийн дүгнэлтийг үндэслэн албан тушаалд дэвшүүлэх замаар уг орон тоог нөхөж болно” гэсэн заалтыг тус тус зөрчиж удирдах албан тушаалтны уг ажлын байранд томилсон байна.

- ТАМШалгалтанд ороогүй Г.Батчулууныг Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын даргаар 2013.4.22-нд түр, Ж.Батбаярыг Цагааннуур сумын МЭҮТ-ийн мэргэжилтний ажлын байранд 2011.12.06-нд тус тус томилсон байна.

Дээрх удирдлагууд болон албан хаагчдын ажлын байрыг зарлаагүй, тухайн ажлын байрныхаа сонгон шалгаруулалтанд ороогүй, нэр дэвшүүлэн дүгнэлт гаргуулаагүй тул эдгээр ажлын байрууд нь Улсын дээд шүүхийн тайлбарт зааснаар⁵ сул ажлын байр байна.

Иргэдийг ТАМШалгалтанд ороогүй байхад ТЖАлбан тушаалд томилон ажиллуулсан байна. **Тухайлбал:**

- ✚ Аймгийн ЗДТГазрын даргын 2008 оны 12 дугаар сарын 31-ний 101 тоот тушаалаар томилогдсон ТЗУХ-ийн хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн Л.Бямбасүрэн, ХБХэлтсийн байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаяр, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Шинэбаяр, Аймгийн засаг даргын шийдвэр хариуцсан мэргэжилтэн бөгөөд Засаг даргын туслах Э.Даваачулуун, Нийгмийн хөгжлийн хэлтсийн Соёл, урлаг, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Нарангэрэл, Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Н.Цэндмаа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн мэргэжилтэн Б.Цэрэндаш, Ц.Чагнаадорж нар байна. Эдгээр иргэд нь тухайн ажилд томилогдсоны дараа мэргэшлийн шалгалтанд орсон байна. Н.Цэндмаа нь 2013 онд ТАМШ өгсөн боловч сонгон шалгаруулалтанд тэнцээгүй тул ажлын байрны шаардлага хангахгүй байна.
- ✚ Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтсийн даргаар Ж.Ганболд, ХХҮХ-ийн даргаар А.Эрдэнэбаатар, БТСХ-ны даргаар Б.Баярсайхан нар тус тус тухайн албан тушаалдаа томилогдсноосоо хойш ТАСЗ-өөс зарласан тухайн ажлын байрныхаа сонгон шалгаруулалтанд орж ТАСЗ-ийн 2009 оны 7 дугаар сарын 7-ны 12 дугаар тогтоолоор баталгаажсан байна.
- ✚ Аймгийн ГХБХБГазрын барилгын хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Цогтбазарыг сонгон шалгаруулалтанд ороогүй байхад 2009 оны 7-р сард томилон ажиллуулсан байна. /2009 оны 12-р сард зохион байгуулагдсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орж тэнцсэн/
- ✚ Аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Батцэцэг, татвар хураагч Э.Энхцэцэг, Ц.Отгонжаргал нар ТАМШ-нд ороогүй, ажлын байранд тавигдах тусгай шаардлагыг хангаагүй байхад төрийн жинхэнэ албанд томилсон бөгөөд Э.Энхцэцэг, Ц.Отгонжаргал нар төрийн албаны тусгай шаардлагыг хангаагүй хэвээр байна.

⁵ Төрийн албаны тухай хуулийн 10.1, 17.3 заасан шаардлагыг хангаагүй этгээд ажиллаж байх нь тухайн албан тушаалд сул орон тоо гарсанд хамааруулж ойлгоно.

- ✚ Аймгийн МХГ-ын орлогч дарга Ч.Пүрэв-Осорыг ТББ болон МАХН-ын даргын сонгуульт ажлыг хийж гүйцэтгэж байсан ба төрд ажилласан туршлагагүй, тухайн албаны ерөнхий шаардлага хангаагүй байхад МХЕГ-ын даргын тушаалаар томилон ажиллуулсан байна.
- ✚ Тээвэр, авто замын газрын авто тээвэр хариуцсан мэргэжилтэн С.Отгонжаргалыг төрийн албаны мэргэшлийн шалгалтанд ороогүй байхад 2013 оны 02 дугаар сард түр хугацаагаар томилон ажиллуулж байна.

Аймгийн ЗДТГазрын ТЗУХэлтсийн мэргэжилтэн Э.Даваачулуун, ХБХэлтсийн мэргэжилтэн Э.Аззаяа, Д.Бямбацогт нарын ажлын байрны зорилго, ямар ажил гүйцэтгэх нь тодорхой бус байсаар байтал үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж байна. Д.Бямбацогтын ажлын байрны тодорхойлолтыг 2013 оны 10 дугаар сарын 31-нд баталгаажуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байранд Татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан Г.Бөхсуурийг УИХ-ын 2003 оны 13-р тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 40-д заасан шаардлагыг зөрчиж шууд томилон ажиллуулсан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтны албан тушаалд тавигдах шаардлага нь нутгийн өөрөө удирдах байгууллагад 1-ээс дээш жил ажилласан, бакалавраас дээш зэрэгтэй, эрх зүйч, хуульч мэргэжилтэй, төрийн удирдлагын менежер, ИТХ, Тэргүүлэгчдийн ажлын албыг мэргэжил арга зүйн хувьд удирдаж явах бүрэн чадвартай зэрэг шалгуурыг сонгон шалгаруулалтанд тавигдах ерөнхий шаардлагад оруулахаар шийдвэрлэж, албан бичгийг сумдын ИТХ-ын дарга нарт болон ТАСЗөвлөлд хүргүүлсэн байна.

Гэтэл ТАСЗ дээрх шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарын цөөнгүй хэсэг нь эдийн засагч, инженер, иргэншил судлал зэрэг мэргэжилтэй байгаа нь ажлын байрны ерөнхий шаардлагад нийцэхгүй байна.

Тухайлбал:

- Цэцэрлэг, Цагаан-Уул сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар томилогдсон ажлын туршлага, мэргэшлийн үр чадваргүй иргэншил судлал, даатгалын эдийн засагч мэргэжилтэй Д.Энхцэцэг, Л.Сэрсмаа нар төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд тухайн ажлын байранд шалгалт өгч 1-д жагссан байна.
- Л.Сэрсмаа нь 2012 онд туслах түшмэлийн ангилалд хамаарах Цагаан-Үүр сумын ДАЭСС хариуцсан мэргэжилтний ажлын байранд шалгалт өгч нөөцөд бүртгэгдсэн байсан ба Цагаан-Уул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн

бичгийн даргын ажлын байранд ТАСЗ нөөцөөс нэрийг дэвшүүлэн тухайн албан тушаалд томилогдсон байна.

- Түүгээрч барахгүй 2013 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан Цагаан-Уул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байрны сонгон шалгаруулалтанд 2012 онд дээд сургууль төгссөн Х.Баянзулыг шалгалтанд оруулан нөөцөд бүртгэн аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэст мэргэжилтнээр нэрийг дэвшүүлэн томилуулсан байна.
- Мөн Баянзүрх сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байрыг зарлаагүй атал удирдах ажилтны мэргэшлийн шалгалтанд ороогүй Б.Уранбилэгийг томилон ажиллуулсан байна.

Ажил олгогчоос ирүүлж байгаа шаардлагаар тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлага нь ижил албан тушаалд өөр өөр буюу тухайн сул ажлын байранд ажиллаж байгаа иргэнд тохирсон шаардлагыг тавьж ТАСЗ-д ирүүлж байгаа явдал нийтлэг болсон байна.

Тухайлбал: Галт сумын ЗДТГазрын даргын ажлын байранд компьютер, программист мэргэжилтэй, Рашаант сумын Тамгын газрын даргын ажлын байранд нягтлан бодогч мэргэжилтэй байх гэсэн шаардлага тухайн албан тушаалд ажиллаж байсан В.Түвшинжаргал, Б.Саранцэцэг нарын мэргэжилд тохируулан ирүүлсэн нь ажил олгогч этгээдээс ийнхүү ирүүлж байгаа нийтлэг зөрчил болоод байна. Одоо тус ажлын байруудад ТАМШ-нд орж тэнцсэн дээрх нэр бүхий 2 иргэн ажиллаж байна.

Ажлын зайлшгүй шаардлагаар сул ажлын байранд ТАМШ өгөөгүй иргэдийг томилон ажиллуулсан дараах ТАХ /иргэд/ байгаа бөгөөд эдгээр ажлын байруудад мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах эсвэл нөөцөөс хангах шаардлага байна.

Тухайлбал:

- Боловсролын газрын мэргэжилтэн П.Хуншагай, Г.Анхтуяа нарыг ажлын зайлшгүй шаардлагаар 1 жилийн хугацаатайгаар 2013 оны 8 дугаар сард томилсон.
- Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн сан хариуцсан мэргэжилтэн, техник программ хангамж, сүлжээ хариуцсан мэргэжилтэн, ажлын байрны бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн зэрэг нийт 9 ажлын байранд зайлшгүй шаардлагаар түр орлон гүйцэтгэгчийг томилон ажиллуулж байна. Мөн Хөдөлмөрийн сайдын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны Б/01 дүгээр тушаалаар Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр П.Ариунбатыг томилсон байна.
- Мөн Тариалан сумын дотоод ажил хариуцсан түшмэлийн албан тушаалд С.Отгонпагам, Рашаант сумын бэлчээр газар тариалан, ЖДҮ хариуцсан мэргэжилтний ажлын байранд Б.Наранцэцэг нарыг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна.

- Нийгмийн Халамж Үйлчилгээний ерөнхий газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 01-ны 19 тоот тушаалаар Хөвсгөл аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр, Мөн ХАХНХ Яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн 2013 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн НХҮЕГазрын даргын 2013 оны 03 дугаар сарын 22-ны 79 дүгээр тушаалаар Д.Дуламжавыг Халамж, үйлчилгээний даргын ажилд жинхэлэн томилсон байна.

Хуурамч дипломтой иргэн ТАМШ өгч улмаар төрийн албанд ажиллаж байсан байна. Ренчинлхүмбэ сумын ЗДТГ-ын даргын ажлын байрны сонгон шалгаруулалтанд орж оноогоороо 1-т жагсаж 2009 оны 12-р сард тус албан тушаалд томилогдсон Ж.Оюунбилэг хуурамч дипломтой болох нь МХГазрын дүгнэлтээр тогтоогдсон байна. Тус сумын засаг дарга болон орлогч дарга нар нь Ж.Оюунбилэгийг эрхэлсэн ажлаа хангалтгүй гүйцэтгэж байгаа талаар ТАСЗ-д удаа дараа хүсэлт гаргаж байжээ.

Иймд: Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй иргэд төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдсон нь төрийн албанд /томилгоонд/ танил тал ихээхэн үүрэг гүйцэтгэсэн бололтой. Мөн төрийн албанд хуурамч дипломтой иргэд ч ажиллаж байхыг үгүйсгэх аргагүй байна.

1.2. Түр тушаалтай иргэнийг тангараг өргүүлж байгаа нь төрийн албаны нэр хүнд алдагдахад хүргэж байна.

ТАЗ-ийн 2003 оны 2 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-д туршилтын хугацаанд үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан төрийн албан хаагчийг холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр төрийн албан хаагчийн

тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагч болгоно гэж заасан байтал журмыг зөрчиж түр болон туршилтын хугацаанд ажиллаж байсан доорх албан тушаалтнуудыг ТЖА хаагчийн тангараг өргүүлсэн байна. **Тухайлбал:**


- Аймгийн МХГ-ын даргын тушаалаар 2012 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Хилийн мэргэжлийн хяналтын хэлтсийн стандарт чанарын хяналтын улсын байцаагчаар Д.Саруултуулыг томилж мөн өдөр ТЖА тангараг өргүүлэн төрийн жинхэнэ албан хаагч болгосон байна. “Д.Саруултуул



нь 2012 онд ШУТИС-ийг төгссөн байх бөгөөд удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд 76,33 оноо авч нөөцөд бүртгэгдсэн нь үнэн болохыг тодорхойлов гэсэн” ТАСЗ-ийн 2012 оны 3/1146 албан тоотыг аймгийн МХГазарт ирүүлсэн байна.

• Эрдэнэбулган сумын газрын даамлын албан тушаалд Б.Энхмааг томилуулах тухай ТАСЗ-ийн 2012 оны 11 дүгээр сарын 23-ны 3/1703 тоот албан бичигт “Газрын даамал өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх болсон тул ажлын байрыг зарлаж өгөх хүсэлтийг манайд ирүүлсэн. Ажлын байрыг орон нутгийн сонгууль зэрэг цаг үеийн ажлаас шалтгаалан зарлах боломжгүй болсон тул ТА-ны нөөцөөс Бат-Эрдэний Энхмааг томилуулахаар санал хүргүүлж байна....” гэжээ.

Аудитаар Д.Саруултуул, Б.Энхмаа нар нь ТАМШ-д ороогүй болох нь тогтоогдсон. Иймд ТАСЗ нь эдгээр иргэдийг төрийн албаны нөөцөд байгаа мэтээр хуурамч баримт үйлдэн тодорхойлолт гаргаж ажил олгогч этгээдэд өгсөн нь нотлогдож байна.



✚ Иргэн Б.Цэлмэгтуяа аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст мэргэжилтнээр ажиллаж байгаад 2013 оны 01-р сарын 5-нд АЗДТГ-ын СТСХэлтсийн төрийн сангийн мэргэжилтнээр томилогдсон байна. Төрийн сангийн мэргэжилтний ажлын байранд туршилтын хугацаанд ажиллаж байхдаа буюу 2013 оны 1 дүгээр сарын 14-нд ТЖА хаагчийн тангараг өргөсөн байна.

✚ БСГазрын мэргэжилтэн Т.Нарантуяа, НДХэлтсийн НДБайцаагч Б.Болорцэцэг, ЭМГазрын мэргэжилтэн Д.Гэрэлтуяа, Ц.Эрдэнэболор, Т.Хөвсгөл, ГХБХБГазрын мэргэжилтэн Б.Ганзориг, Мөрөн сумын нийгмийн ажилтан Ш.Энхтуул нар төрийн албан тушаалд томилогдон ажилласан

туршилтын хугацаанд төрийн албаны тангараг өргөсөн байна. Аймгийн МХГазрын улсын байцаагч Ц.Үүрийнтуяа, АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Бэхбаяр нарыг жирэмсэн, амаржсан ТАХ-ын оронд түр хугацаагаар томилон ажиллуулсан бөгөөд ийнхүү ажиллаж байхад нь ТЖА хаагчийн тангараг өргүүлсэн байна.

Энэ нь ажил олгогч этгээдүүд тухайн иргэний мэдлэг, ур чадвар, туршилтын хугацаа зэргийг харгалзахгүй ТЖА хаагч болгон тангараг өргүүлсэн нь хууль зөрчсөн ба улмаар төрийн албаны үнэ цэнийг алдагдахад хүргэж байна.

1.3. “Тангараг” өргөсөн төрийн жинхэнэ албан тушаалтныг ажлаас халах нь эрх бүхий албан тушаалтны дурын асуудал болсон байна.

Хөвгсөл аймгийн хувьд тангараг өргөсөн ТЖАХ-ыг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн явдал нилээдгүй байна. **Тухайлбал:**

✚ Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга С.Мөнхжаргалыг аймгийн Засаг даргын 2013 оны 21 дүгээр захирамжаар үүрэгт ажлаас чөлөөлсөн нь үндэслэлгүй байсан тул шүүхийн шийдвэрээр эгүүлэн ажилдаа томилогдсон байна.

✚ Аймгийн ЗДТГ даргын 2008 оны 100 дугаар тушаалаар Д.Цэцэгмааг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн бөгөөд Цэцэрлэг сумын Засаг дарга Б.Болдод танай сумын ЗДТГазраас 2008 онд зарласан ЗДТГазрын даргын ажлын байранд ТАМШалгалтанд орж хамгийн өндөр буюу 49 оноо авч тэнцэн ТАСЗ-ийн 2008 оны 07 дугаар тогтоолоор баталгаажсан тул Д.Цэцэгмааг сумын ЗДТГазрын даргаар томилж, шийдвэрийнхээ 1 хувийг аймгийн ТАСЗ-д ирүүлнэ үү гэсэн ТАСЗ-ийн 2009.12.29-ний 3/2033 тоот албан бичгийг хүргүүлж байжээ. Д.Цэцэгмаа /49 оноо/, Н.Пүрэвсүрэн /42 оноо/ нар Цэцэрлэг сумын засаг даргын тамгын газрын даргын сул ажлын байр буюу удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн боловч тухайн үед Д.Цэцэгмаа АЗДТГ-ын ТЗУХ-ийн дотоод ажил шуурхай мэдээлэл хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан байна. ТАЗ-өөс аймгийн ТАСЗ-д ирүүлсэн 2009 оны 3 дугаар сарын 185 тоот албан бичигт Н.Пүрэвсүрэнг тус сумын ЗДТГ-ын даргын ажлын байранд томилох үндэслэлтэй гэж ирүүлсэн байна. Цэцэрлэг сумын засаг даргын 2009 оны 02 дугаар сарын 13-ны 17 тоот захирамжаар Н.Пүрэвсүрэнг ЗДТГ-ын даргаар томилсон байна.

✚ Жаргалант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сул ажлын байранд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд орж тэнцэн нөөцөд бүртгэгдсэн Э.Бат-Эрдэнийг ажилд томилуулахаар нэрийг нь дэвшүүлэн хүргүүлсний дагуу 2011 оны 4 дүгээр сард сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Э.Бат-Эрдэнийг түр томилсон бөгөөд 1 жилийн дараа Э.Бат-Эрдэнийг шалтгаангүйгээр ажлаас чөлөөлсөн байна. Мөн 1 жил ажилласантай тэнцэх хэмжээний тэтгэмжийг ОНО-ын

давсан орлогоос гаргах тухай Жаргалант сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гаргасны дагуу 280.7 мянган төгрөгийн тэтгэмж олгож төсөвт хохирол учруулсан байна. Гэтэл шүүхийн шийдвэрээр Э.Бат-Эрдэнэ эгүүлэн ажилдаа томилогдсон байна.

✚ Аймгийн засаг даргын 2008 оны 345 дугаар захирамжийг үндэслэн аймгийн ЗДТГ-ын дарга 2008 оны 12 дугаар сарын 100 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн Д.Бямбацогт, Д.Доржханд, Д.Дуламжав, М.Бат-Очир, Д.Цэцэгмаа, Г.Сүхбаатар нарыг ажлаас чөлөөлсөн байна. Дээрх нэр бүхий мэргэжилтнүүдийн албан тушаал, ажлын байр нь хэвээр хадгалагдан үлдсэн хэдий ч тухайн ажлын байруудад өөр иргэдийг томилон ажиллуулсан байна.

✚ АЗДТГазрын ХБХэлтсийн мэргэжилтэн Д.Бямбацогт хэд хэдэн шатны шүүхийн шийдвэрээр эгүүлэн томилогдон ажиллаж байна. ТАСЗ-ийн 2010 оны 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: Г.Төмөрбаатар- “ЗДТГ-ын ХБХ-ийн дарга Х.Ган-Очирын албан бичиг, аймгийн ЗДТГазрын 2010 оны Б-02 дугаар тушаал зэргийн талаар шийдвэрлэхдээ” Шүүхийн шийдвэрийг биелүүлж Б-02 дугаар тушаалаар томилсон. Д.Бямбацогт нь дэд бүтэц хариуцаж байсан, аймгийн ЗД-ын 2008 оны 345 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоог тогтоохдоо ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст Архитектор, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн байхаар шийдвэрлэсэн. Х.Ган-Очир даргын асуудлыг хүлээн авах үндэслэлтэй гэжээ. Г.Сувд-Аймгийн засаг даргын захирамж болон ажлын байрны тодорхойлолтонд юу гэж заасан юм бэ?. Ерөнхий зураг нь гарсан жирийн нэг халуун усны зургийг хийж чадахгүй гэж байгаа нь чадвараа харуулж байна. Тэр болгоныг мэргэжлийн байгууллагаар хийлгээд байвал төсөв, санхүү хүндэрнэ. Ерөнхий зураг гарсан зүйлийг мэргэжилтэн хийх л хэрэгтэй байдаг ийм бол хэцүү шүү гэж тус тус ярилцсаны эцэст ТАСЗ-ийн олонхийн саналаар аймгийн ЗД-ын 345 дугаар захирамжаар тогтоосон бүтцээ баримтлан тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа Э.Аззаяаг эгүүлэн томилох нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргасан байна. Мөн ажлын байрны тодорхойлолт болон албаны чиг үүрэгт тусгагдсан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг “F” буюу “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн гэж Д.Бямбацогтыг албан тушаал бууруулж ажиллуулахаар аймгийн ЗДТГазрын даргын 2012 оны 01 дүгээр сарын 04-ны Б/01 тоот тушаал гарсан байна. Эндээс харахад: Аймгийн засаг даргын аймгийн ЗДТГазрын бүтэц, орон тоог зөвшилцөх тухай гаргасан 2008 оны 345 дугаар захирамжаар “дэд бүтцийн бодлого хариуцсан” гэснийг өөрчилж “Ерөнхий архитектор, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн” гэж өөрчлөн тогтоож ТЖАХ, уул, уурхайн ашиглалтын инженер мэргэжилтэй, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Д.Бямбацогтыг ажлаас чөлөөлж, архитектор мэргэжилтэй Э.Аззаяаг уг албан тушаалд томилуулах санаа өвөрлөсөн нь дээрх нөхцөл байдлыг зохиомлоор бий болгоход хүргэсэн гэж үзэхэд хүргэж байна. Иргэн Д.Бямбацогт Монгол улсын Хүний эрхийн үндэсний комисст гаргасан гомдолдоо 2009 оноос хойш 3 удаа

ажлаас халагдаж, эргүүлэн томилогдсон тухайгаа дурьдаад аймгийн засаг даргын Тамгын газрын дарга Г.Төмөрбаатар, ХБХэлтсийн дарга Х.Ган-Очир нар “чамайг ажлаа хийхийг чинь харнаа” гээд салаавч үзүүлэх”, “чи энд байя гэж бодож байгаа бол олон юм яриад байхгүй шүү”, “шүүхийнхээ асуудлыг зогсооно шүү” гэх зэргээр дарамт үзүүлдэг тухай дурьджээ. Иймд аймгийн Засаг дарга Л.Цэрэнжавд ирүүлсэн Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын 2013.05.27-ны 3/14 тоот албан шаардлагад “Тамгын газрын дарга Г.Төмөрбаатар, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-Очир нар нь иргэн Д.Бямбацогтын хөдөлмөрлөх эрхийг ноцтой зөрчөөд зогсохгүй түүний хэвийн ажил хөдөлмөрөө эрхлэхэд нь саад учруулж, ажлын байрны дарамт шахалт үзүүлэх, ялгаварлах, хавчин гадуурхах үйлдлийг удаа дараа гаргасан байна” гэжээ.

Эрх бүхий албан тушаалтнууд ТЖА хаагчийг үндэслэлгүй ажлаас чөлөөлдөг, халахаар шийдсэн албан хаагчийг ажлын байранд дарамтлах, хөдөлмөрлөх эрхийг нь зөрчих, зэрэг үйлдлийг гаргахаас гадна хэн дуртай иргэнээ төрийн албанд томилуулах, нэр дэвшүүлэх асуудал ТАСЗ-ийн дурын асуудал болоод байна.

1.4. Ажлаас чөлөөлөгдсөн иргэдэд 6 сарын тэтгэмжийг үндэслэлгүй олгож байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2008 оны 12 дугаар сарын 100 дугаар тушаалаар мэргэжилтэн Д.Бямбацогт, Д.Доржханд, Д.Дуламжав, М.Бат-Очир, Д.Цэцэгмаа, Г.Сүхбаатар нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлж тэдгээрт 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн 9816,2 мянган төгрөгийн мөнгөн тэтгэлгийг олгосон нь ТАТ хуулийн 27.2.3⁶, 27.2.4⁷ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Зөрчилд аймгийн ЗДТГазрын даргаар ажиллаж байсан Ц.Жамсранжаваар төлүүлэхээр 9826100/есөн сая найман зуун хорин зургаан мянга нэг зуун/ төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Аймгийн ЗДТГазрын үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтнээр ажиллаж байгаад бүтцийн өөрчлөлтөөр

⁶ 27.2.3. Төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр) -ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авна;

⁷ 27.2.4. төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно;

албан тушаалаасаа чөлөөлөгдсөн Д.Бямбацогт шүүхийн шийдвэрээр ХБХ-ийн мэргэжилтнээр эгүүлэн томилогдон ажиллаж байна. Зөрчилд АЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатараар төлүүлэхээр 4264230/дөрвөн сая хоёр зуун жаран дөрвөн мянга хоёр зуун гуч/ төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Төрийн албаны тухай хуулийн 30.2-т зааснаар “тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид төрийн албанд ажилласан хугацааг харгалзан 36 хүртэл сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно” гэсний дагуу тэтгэмжээ авсан боловч засаг даргатай тохирсон, эсвэл дараагийн хүн томилогдоогүй гэдэг шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллаж байгаа төрийн албан хаагчид байна.

Тухайлбал:

Хүснэгт№3

Овог нэр	Албан тушаал	Тэтгэмж авсан огноо	Тэтгэмжийн дүн /мянган төгрөгөөр/
Б.Сэнгэбазар	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГазрын дарга	2013оны 4 дүгээр сар	22973,1
Б.Дашцэцэг	Цэцэрлэг сумын төрийн сангийн төлөөлөгч	2013 оны 2 дугаар сар	10403,3

Тэтгэвэрт гарах үндэслэлээр ажлаас чөлөөлөгдөн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон атлаа үргэлжлүүлэн ажиллуулсан, бүтцийн өөрчлөлт гэдгээр дулдуйдан ажлын байр нь хэвээр байгаа ТЖА хаагчдыг ажлаас чөлөөлж 6 сарын тэтгэмж олгосон, өөр байгууллагын мэдэлд шилжүүлсэн атал тухайн ажлын байранд шинээр томилгоо хийсэн зэрэг нь хяналт сул, хуульд захирагдахгүй, дураараа аашилж байгааг харуулж байна.

1.5. Аймгийн Засаг дарга бусдын ажилд хутгалдаж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.4-т “Аймаг, нийслэл, сум дүүргийн Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж чөлөөлнө” гэсэн заалтыг зөрчиж Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолыг үндэслэн гаргасан аймгийн Засаг даргын 2008 оны 345 дугаар захирамжаар аймгийн ЗДТГазрын бүтэц, орон тоог тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай гаргасан Засгийн газрын 2008 оны 67 дугаар тоогтоолоор аймгийн удирдлагыг Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга байхаар, орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл орон тоотой байхаар тогтоосон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 3-н удирдлага болон засаг даргын зөвлөхтэй бүгд **43** орон тоогоор ажиллаж батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлсэн, мөн засаг даргын зөвлөх ажиллуулж төсвөөс цалинжуулж байгаа зэрэг нь төсөвт хүндрэл учруулахад хүргэж байна.

Аймгийн ЗДТГазар 2013 онд ТЗУХэлтэст-1, ХШҮТасагт-1, ХБХэлтэст-1 орон тоог тус тус нэмсэн, үндэслэлгүй ажлаас чөлөөлөгдсөн хэмээн шүүхийн шийдвэрээр нөхөн олгосон Д.Бямбацогтын цалинд 7,5 сая төгрөг зэргээс шалтгаалан цалингийн сан 32,9 сая төгрөгөөр дутагдаж байгаа талаар дурьдаад үүнээс 18,5 сая төгрөгийг давсан орлогоос зохицуулж өгөхийг Аймгийн ИТХ-д уламжлаад байна. Иймд батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан ажиллахыг АЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатарт албан шаардлага хүргүүлэв.

Татварын Ерөнхий газраас ирүүлсэн 3/610 тоот албан бичигт “Хөвсгөл аймгийн Татварын хэлтсийн 2013 онд ажиллах орон тооны дээд хязгаарыг 51-ээр баталж улмаар орон тоог 2013 оны 4 дүгээр сарын 01-ний дотор батлагдсан хязгаарт багтаан зохион байгуулж хариуг ирүүлнэ үү” гэжээ. Аймгийн Татварын хэлтэс 2013 оны 10 дугаар сарын байдлаар 57 орон тоотой ажиллаж удирдах дээд байгууллагаас баталсан орон тооноос **6** орон тоогоор илүү байгаа нь аудитаар тогтоогдлоо.

Тус хэлтэст ТАМШалгалтанд ороогүй, тухайн ажлын байрны тусгай шаардлагыг хангаагүй иргэд ч ажиллаж байгаа бөгөөд ажлын байр нь дэс түшмэлийн ангилалд хамаарах албан тушаал байсаар байтал туслах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалын ангилалаар төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч томилогдсон албан хаагчид цөөнгүй байна.

Аудитаар Татварын ерөнхий газраас баталсан орон тооны хязгаарт багтаан ажиллах талаар албан шаардлагыг дарга В.Баяраад хүргүүлэв.

1.6. Төрийн чиг үүргийг хамаарал бүхий этгээдүүд гүйцэтгэх сонирхолтой байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар “Хамааралтай этгээд” гэж Нийтийн албан тушаалтны эхнэр, нөхөр, хамтран амьдрагч нэг, хоёр дахь үеийн төрөл, садан, үрчилсэн эцэг эх болон хүүхэд, нэг дэх үеийн худууд мөн нөхцөл байдлын улмаас нэгдмэл сонирхолтой байж болзошгүй бусад этгээд байна гэж заасан.

Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд нь төрийн улс төрийн, захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтан, Төрийн, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гэж заасаар байтал хамаарал бүхий этгээдүүд удирдах, хяналт тавих албан тушаалд ажиллаж байгаа нь хуулийг гууль болгосонтой нэгэн адил болжээ.

Тухайлбал:

- Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав аймгийн ЗДТГ-ын ХБХэлтсийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалт, гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн Ж.Жавзанпагмын хадам ах буюу хамаарал бүхий этгээд байна.
- Жаргалант сумын засаг дарга Б.Должинсоргодог, Засаг даргын орлогч Ж.Амартүвшин, Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Б.Дашцэрэн нар төрөл садангийн хамааралтай байна.
- Галт сумын эмийн эргэлтийн сангийн эрхлэгч Д.Сайнбуян, эмнэлгийн даргаар түр томилогдон ажиллаж байгаа П.Наранцэцэг нар хамаарал бүхий этгээд байх жишээтэй. Наранцэцэгийн төрсөн дүү нь Сайнбуянгийн нөхөр. Сумын Засаг дарга Д.Эрдэнэхуяг нь халамжийн ажилтан П.Цолмонжаргалтай хамаарал бүхий этгээд байна.
- БСГазрын даргаар Н.Баатар-Очир түүний эхнэр Б.Баярсайхан Мөрөн сумын “Авьяс-8” дугаар сургуулийн захирлаар ажиллаж байна.

Эдгээр нь албан үүргийн дагуу шууд хяналт тавьдаг, удирдах, гэрээ байгуулах зэргээр хамаарал бүхий этгээд болохын хувьд Төрийн албаны тухай хуулийн 16.2.3-д заасан⁸ төрийн жинхэнэ албан тушаалын эрхлэх болзол журмыг зөрчиж байна.

Сүүлийн үед төрийн албанд танил тал, арын хаалгаар ажилд орох явдал ихэссэн, сонгон шалгаруулалтыг шударга бусаар зохион байгуулж төрийн албанд нутаг нуга, ах дүүгийн хэлхээ холбоо бий боллоо гэсэн мэдээллийг иргэдээс ирүүлж байсан бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлагуудын дарга нарын дийлэнх хувь нь нутаг зүгийнх байгаад бие биэндээ хяналт тавьж ажиллахад учир дутагдалтай болсон байна.

⁸ 16.2.3. хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

1 ДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

- 1. Эрх бүхий албан тушаалтнууд өөрийн үзэмжийн дагуу албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг адил ажлын байранд өөр өөр ерөнхий шаардлага тавьдаг, тухайн албан хаагчдад тохируулж шаардлага тавьдаг байна. Үүнийг нарийвчлан зохицуулах эрх зүйн зохицуулалт МУ-д үгүйлэгдэж байна.**
- 2. Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа зарим иргэд тухайн ажлын байранд хамааралгүй ангилалд шалгалт өгсөн, ТАМШ өгсөн ангилалаас өөр ангилалын албан тушаалд томилогдох, ажлын туршлагагүй иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд оруулан нөөцөд бүртгэсэн, төрийн захиргааны зарим албан хаагчид ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй байгаа нь Улсын Дээд Шүүхийн тайлбараар сул ажлын байр байна.**
- 3. Батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж ажиллаагүйгээс төсвийг хэтрүүлэхэд хүргэсэн, төрийн албанд нутаг нуг, ах дүүгийн хэлхээ холбоо бий болсон бөгөөд төрийн захиргааны албан тушаалд ажиллаж буй зарим албан хаагчид их дээд сургуульд сураагүй, хуурамч дипломтой байж болзошгүй байна.**



Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-аар Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн 126 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул шинээр баталсан журмыг мөрдөн ажиллаж байна.

Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл нь:

- Тухайн салбар, орон нутгийн хэмжээнд төрийн албаны шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, төрийн боловсон хүчний бодлогын удирдамжаар хангах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулахад мэргэшлийн зөвлөлгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг болон төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох ажилтныг нөөцөд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх, тэрчлэн нөөцийн сангаас албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх, нөөцийн сангийн мэдээллээр үйлчлэх;
- УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу удирдах албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтлан сонгон шалгаруулж дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлэх;
- 2009 онд баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ыг, 2013 оны 86 дугаар тогтоол “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай” болгон шинэчилсэн бөгөөд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах зэрэг болон хууль, журамд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах зорилготой юм.

2.1. Төрийн албаны мэргэшлийн шалгалт цахим хэлбэрт шилжсэн нь шалгуулагчдаас хурд, техник хэрэглээ, бэлтгэлийг шаардах болсон байна.

Тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй зарим иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах болон төрийн

захиргааны албанд томилж байна. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэн ямар албан тушаалын ангилалд шалгалт өгнө тэр ангилалдаа ажилд томилогдох, нөөцөд бүртгэгдэх ёстой⁹.

Аудитаар дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

✚ Аймгийн ТАСЗ-өөс 2009 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт “Галт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажил”-ын байранд өрсөлдсөн иргэн И.Ганбаатар ТА-ны тухай хуулийн ерөнхий шаардлага хангаагүй, дээд боловсрол эзэмшээгүй байхдаа мэргэшлийн шалгалтанд орж 9-т жагсан нөөцөд бүртгэгдэн улмаар 2009 оны 1 дүгээр сард тус албан тушаалд томилогдсон байна. И.Ганбаатар нь ТАМШ өгснөөсөө хойш 2012 онд “Засагтхан” Дээд сургуулийг төгссөн тул ТАМШ өгөхдөө тухайн ажлын байранд тавигдах тусгай шаардлагыг хангаагүй иргэнийг ТАСЗ шалгалтанд оруулахаар бүртгэсэн нь ТАСЗ *хууль журмаа зөрчиж байгаагийн тод жишээ юм.*

✚ Төрийн албаны салбар зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаар тогтоолоор баталсан “Нөөцийн жагсаалтын бүртгэл”-ээс *харахад:* Их -Уул сумын ИТХ тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байранд 9 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэн бөгөөд онооны дарааллаар 2-т жагссан Г.Пүрэвсүрэнг ТАСЗ-ийн 2009 оны 28 дугаар тогтоолоор тухайн албан тушаалд томилуулахаар нэрийг нь дэвшүүлсэн хэдий ч хараахан томилогдон ажиллаагүй байна. Г.Нансалмаа 2007 оноос хойш энэ албан тушаалд ажиллаж байгаа бөгөөд удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд ороогүй хэмээн 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “ТЖА-ны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах ажлын хэсгийн шалгалтын илтгэл”-ийн баримтанд дурьдагдсан байна. Г.Нансалмаа 2011 онд Их-Уул сумын ИТХ тэргүүлэгчдийн нарийн бичгийн ажлын байранд өрсөлдөн нөөцөд бүртгэгдсэн байснаас харахад шаардлага хангаагүй иргэнийг ажиллуулж байсан нь тогтоогдсон.

✚ Цагаан-Уул сумын ИТХ-ын дарга н.Азбаярт “ иргэн Лхагважавын Сэрсмаа нь 2012 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан ТАМШ-нд орж тэнцэн баталгаажсан болно” гэж ТАСЗ тодорхойлолт хүргүүлсэн байна. Гэтэл Л.Сэрсмаа нь ТАМШ-нд туслах түшмэлийн ангилалд хамаарах Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын дотоод ажил эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний ажлын

⁹ 2009 оны 99 дүгээр тогтоолын 6.3. Нөөцөд байгаа иргэн мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын зэрэглэлтэйгээ адил зэрэглэлийн төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд томилогдон ажиллаж болно. Хэрэв Төрийн албаны зөвлөл болон аймаг, нийслэл дэх салбар зөвлөл нөөцөд байгаа иргэн тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн тохиолдолд мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын зэрэглэлээсээ тухайн ангилал дотроо түүнээс дээшхи зэрэглэлийн төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж болно.

байрны сонгон шалгаруулалтанд орж 28-д /30-аас/ жагсжээ. Дээрх тодорхойлолтын дагуу Л.Сэрсмаа 2013 оны 1 дүгээр сард тус сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдсон. Улмаар 2013 оны 5-р сард зохион явуулсан удирдах ажилтны /тухайн ажлын байрны/ сонгон шалгаруулалтанд орж 1-д жагссан байна. Энэ нь Л.Сэрсмааг ажилд томилуулахад хэрэглэсэн ТАСЗ-ийн башир арга нэг гэж харагдаж байна.

✚ Аймгийн ТАСЗ-ийн дарга Г.Төмөрбаатарын 2012.11.28-ны 3/1724 тоот албан бичигт “Буянтогтохын Батбаярыг төрийн албаны мэргэшлийн шалгалтанд ортол тухайн ажлын байранд ажиллууж байхыг мэдэгдье” гэснийг үндэслэн БОАЖГазрын дарга Ч.Уртнасан нь Цаганнуур сумын байгаль хамгаалагчийн сул ажлын байранд төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд ороогүй, тусгай шаардлагыг хангаагүй иргэн Б.Батбаярыг томилон ажиллуулсан байна.

✚ ТАСЗ-ийн 2011 оны 09 дүгээр сарын 29-ний 3/1506 тоот албан бичигт Гантулгын Бямбасүрэнг Алаг-Эрдэнэ сумын байгаль хамгаалагчаар түр томилон ажиллуулах шийдвэр гаргахдаа аймгийн ТАСЗ-д албан ёсоор хандаж, ТАСЗ-ийн дүгнэлтийг аваагүй байх тул тус газрын даргын 2011 оны 43 тоот тушаалаа эргэн хянаж үзэхийг зөвлөж байна хэмээн БОАЖГазрын дарга Ч.Уртнасанд тус тус хүргүүлжээ.

“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2-оос доошгүй иргэнийг нэр дэвшүүлэх атал удирдах албан тушаалд өрсөлдөгчгүйгээр зөвхөн нэг иргэнийг нэр дэвшүүлсэн¹⁰ байна. **Тухайлбал:**

2009 онд Ханх сумын ЗДТГ-ын даргын ажлын байранд К.Одгэрэл, Ц.Батдорж нар тэнцэн нөөцөд бүртгэгдсэн атал 2-рт жагссан Ц.Батдоржийг, Цагаан-Уул сумын ЗДТГ-ын даргын сул ажлын байранд Д.Дарамжавыг, Их-Уул сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сул ажлын байранд Г.Пүрэвсүрэнг, Эрдэнэбулган сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сул ажлын байранд Б.Хишигсүрэнг, Цэцэрлэг сумын ЗДТГ-ын даргын сул ажлын байранд Д.Цэцэгмааг,

2010 онд Цагаан-Уул суманд Д.Цэцэгмааг, Жаргалант суманд Э.Бат-Эрдэнийг, Түнэл суманд Г.Баяржаргалыг, Цэцэрлэг суманд Н.Түмэндэмбэрэлийг тус тус ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сул ажлын байранд

2011 онд Эрдэнэбулган суманд Б.Эрдэнэ-Оюуныг, Түнэл суманд Н.Баянжаргалыг, Их-Уул суманд Б.Мөнхзулыг, Жаргалант суманд Ж.Энхбаярыг, Баянзүрх суманд Э.Ариунаа нарыг тус тус ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сул ажлын байранд,

¹⁰ УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол 33.ᠠᠶᠢᠶᠢ ᠭᠡᠳᠡᠳᠡᠳᠡ 9-ᠡᠡᠢ “ᠠ”, “ᠠ”, “ᠠ”, 10-᠔ ᠴᠠᠠᠨᠠᠢ ᠠᠡᠠᠢ ᠣᠣᠠᠠᠡ ᠠᠴᠢᠳᠡ 2-ᠢᠨ ᠠᠢᠨᠠᠴᠢᠡ ᠡᠳᠠᠶᠢᠡᠡ ᠢᠶᠡᠡᠡ


2012 онд Тариалан суманд Д.Баасанбатыг, Ханх суманд Б.Баасансүрэнг, Ренчинлхүмбэ суманд О.Энхтүвшинг нарыг тус сумдын ЗДТГ-ын даргад, Цэцэрлэг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад Д.Энхцэцэгийг, Цагаан-Үүр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад С.Үүрийнбаярыг,

2013 онд Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын даргад М.Оюумааг, Цагаан-Уул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад Л.Сэрсмааг, Түнэл сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргад Д.Далайжаргал нарыг тус тус дэвшүүлжээ.

Дээрх байдлаас харахад зарим сумдын удирдлагууд хэд хэд солигдсон байгаа нь оновчтой сонголт хийгдэхгүй, ТАСЗ тийм нөхцөлийг бүрдүүлэхгүй байгааг харуулж байна.

Мэргэшлийн шалгалтын талаарх мэдээлэл

ТЖА-нд анх орох иргэдээс авсан мэргэшлийн шалгалтын мэдээг графикаар харуулбал:





Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт

Хүснэгт №:4

№	Агуулга	2009он	2010он	2011он	2012он	2013он
1	Зарласан ажлын байрны тоо	14	0	5	5	3
2	Авсан шалгалтын тоо	2	0	1	2	1
3	Шалгалт өгсөн иргэний тоо	55	0	32	108	49
4	Нөөцөд бүртгэгдсэн иргэний тоо	55	0	23	103	49
5	Үүнээс ажилд орсон иргэдийн тоо	12	0	4	5	1

Эх сурвалж: ТАСЗ-өөс бидэнд ирүүлсэн судалгаа, ажлын баримт.

Дээрх графикуудаас харахад: Ажлын байрны тооноос 6-18 дахин илүү иргэн шалгалтанд орж 50-60 хувь нь шалгалтанд тэнцэж нөөцөд бүртгэгдсэн байна. ТАСЗ дангаараа зохион байгуулдаг удирдах ажилтаны сонгон шалгаруулалтанд орсон иргэдийн 72-100 хувь нь шалгалтанд тэнцэн нөөцөд бүртгэгдэж байна. Эндээс төрийн албан хаагч болох хүсэлтэй иргэд цөөнгүй байгааг харж болох бөгөөд удирдах ажилтны мэргэшлийн шалгалт иргэдэд ойлгомжтой энгийн байдаг бололтой.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын дагуу энэ оны 10 сард зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалт нь цахим хэлбэрээр явагдсан. Мэргэшлийн шалгалтад нийт 492 хүн бүртгүүлснээс туслах түшмэлийн албан тушаалд 26 иргэн, дэс түшмэлийн албан тушаалд 3 иргэн, нийт 29 иргэн тэнцсэн байна. Үүнийг өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй бага иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдсэн байгааг харж болно.

Цахим хэлбэрт шилжсэн нь нэг талаараа иргэдийн хүсэн хүлээж байснаар мэргэшлийн шалгалт шударга, бодитой болсныг илэрхийлж байх бөгөөд нөгөө талаар шалгуулагчдаас хууль эрх зүйн болон ерөнхий мэдлэг, бичиг хэрэг,

компьютертой харьцах чадвар, техник хэрэглээ, хурд зэрэг үр чавдарыг шаардах болсон байна.

2.2. Сул орон тоог мэдээлэх явц иргэдийг төөрөгдүүлж байна.

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийг боловсруулан баталж мөрдүүлэхэд баримталсан тулгуур зарчмуудын нэг бол **“Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх”** буюу **“Мерит”** зарчим бөгөөд уг зарчмын хүрээнд төрийн албан хаагчдын ажлын байрны тогтвор, суурьшилтай холбоотой харилцааг хуульчилсан байна.

Үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх **төрийн тусгай** албан тушаал, төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, тус бодлогыг хэрэгжүүлэх үүднээс захиргааны удирдлагаар хангах чиг үүргийг **төрийн захиргааны албан тушаал** гэж төрийн жинхэнэ алба хэмээн хуульчлан өгсөн байна. Тиймээс ямарч үед төрийн алба тасралтгүй үргэлжилж байх үүднээс сул ажлын байр гарах бүрт ажил олгогчийн зүгээс нийтэд мэдээлж, мэдлэг туршилгатай албан хаагчийг авч ажиллууллах нь ажил олгогчийн гол үүрэг юм.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын 2.1-д “Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1¹¹, 17.4¹²-т заасны дагуу нөхөх боломжгүй тохиолдолд иргэнийг сонгон шалгаруулж авах захиалгыг байгууллага нь ажлын байр тус бүрээр гарган, “Төрийн албаны зөвлөлөөс баталсан Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтын хамт энэхүү журмын 1.4-т¹³ заасан харьяаллын дагуу Төрийн албаны зөвлөл болон аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлд хүргүүлнэ” гэжээ.

Ажил олгогчид ажлын байранд нийцсэн бус ажилтанд нийцсэн захиалгыг ирүүлэх, сул орон тоог мэдээлэх явц иргэдийг төөрөгдүүлсэн байна. **Тухайлбал:**

¹¹ ТАТХ 17.1. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.

¹² ТАТХ 17.4. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина.

¹³ Журмын 1.4.2-т Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалд анх орох иргэнээс авах мэргэшлийн шалгалтыг аймаг, нийслэл дэх Салбар зөвлөл дангаараа

Жаргалант сумын “Байгаль орчны хяналтын улсын байцаагч”-ийн сул ажлын байрны захиалга ирүүлэхдээ дээд боловсролтой, бакалавр зэрэгтэй, эрх зүйч, экологи, байгаль хамгаалал гэж тус тус зааснаар “Эрх зүйч” мэргэжилтэй иргэн Б.Байгалмаа сонгон шалгаруулалтанд орж 81,2 оноогоор 1-рт жагссан боловч тус ажлын байранд орж ажиллах боломжгүй болсон байна. Энэ нь Засаг дарга Бямбажав, МХГ-ын дарга Д.Лхагвасүрэн нар энэ ажлын байранд Эрх зүйч хүн тохирохгүй гэж хариу өгөн томилоогүй хэмээн иргэн Б.Байгалмаа ТАСЗ-д ирүүлсэн өргөдөлдөө дурьдсан байна. Эрх зүйч, Экологи, байгаль хамгаалал чиглэлээр мэргэшсэн, төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх гэж ирүүлсэн хэрнээ дээрх үйлдлийг гаргасан нь уялдаа холбоо байхгүй, анхнаасаа ажлын байрны захиалгаа өгөхдөө иргэдийг төөрөлдүүлсэн байна.

Сумдын бэлчээр газар тариалан, ЖДҮ, үйлчилгээ хариуцсан мэргэжилтний сул ажлын байрны сонгон шалгаруулалтад тавих шаардлагаар болон уг ажлын байрыг нөөцөөс нөхсөн эм зүйч, инженер, мал зүйч, био технологич зэрэг мэргэжлийн иргэд Жаргал, Шинэ-Идэр, Галт, Арбулаг, Баянзүрх зэрэг сумдад томилогдон ажиллаж байна. Энэ нь тухайн ажлын байрны тодорхойлолтод заагдсан Бэлчээр, ашиглалт, хамгаалалтын үйл ажиллагаа явуулах зорилго бүхий ажлын байранд нийцэхгүй болох нь аудитаар тогтоогдсон бөгөөд ажил олгогчид ажлын байранд нийцсэн бус ажилтанд нийцсэн захиалга ирүүлдэг байна.

Ажил олгогч нь ажлын байрны сул орон тооны ерөнхий болон тусгай шаардлагыг тавихдаа тухайн ажлын байрны чиг үүрэгт нийцүүлэхгүйгээр ажлын байрны мэргэжлийг зааж сонгон шалгаруулалт явуулсан нь тухайн иргэнд тохирсон шалгуурыг тавих, иргэдийг чирэгдүүлэх байдлыг үүсгэсэн байна.

2.3. Ажил олгогч нь нөөцийн бүртгэлээс шалгуур хангасан иргэнийг сонгож авахад хүндрэлтэй байна.

ТАСЗ нь сул ажлын байрыг нөөцөөс бүрдүүлэхээр зохион байгуулахдаа тухайн ажил олгогчийн сонгож авах эрхийг хязгаарлахаар барахгүй тухайн сул ажлын байранд саналаа ирүүлсэн гэдэг нэрийдлээр зөвхөн ганц иргэнийг нөөцөөс дэвшүүлэн ТАСЗөвлөлийн хуралд танилцуулан хамтын шийдвэр нэрээр тухайн байгууллагад хүргүүлж байгаа нь зөвхөн томилуулах сонирхолтой иргэний нэрийг дэвшүүлж байна гэлтэй. *ТАСЗ-ийн хуралдааны тэмдэглэлээс харахад:* Сул ажлын байранд зөвхөн нэг иргэнийг дэвшүүлж байсан. Иймд нөөцөөс хангахаар шийдвэрлэсэн сул ажлын байрны зар, мэдээлэл иргэдэд хүрэхгүй, иргэд төдийлөн мэдээллийг олж авч чадахгүй байгааг харуулж байна.

ТАСЗ нь төрийн албаны тухай хуулийн 17.3-д “...онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү

хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ” гэсэн атал **ажилд томилж хариу ирүүл** хэмээн албан тоот явуулдаг байна¹⁴.

Ажил олгогч эрх бүхий албан тушаалтан нь өөрийн эрх үүргийг бүрэн ойлгоогүйн улмаас нөөцөөс нэр дэвшүүлсэн иргэнийг ямарч сонголтгүйгээр ажилд томилдог байдал хэвийн үзэгдэл болсон байна. **Тухайлбал:**

✚ Улаан- Уул сумын засаг дарга Н.Тагнанжавд “Танай сумын ЗДТГ-аас зарласан газрын даамлын сул ажлын байрыг ТАМШ-нд орж нөөцөд бүртгэлтэй иргэдээс хангах арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд бүртгэгдсэн иргэдээс тусгай шаардлагыг илүү хангаж байгаа П.Цолмонгийн нэрийг дэвшүүлсэн аймаг дахь ТАСЗ-ийн тогтоолыг хүргүүлж байна. Иргэн П.Цолмонг тухайн ажлын байранд нь томилж шийдвэрийнхээ хувийг манайд ирүүлнэ үү” гэсэн ТАСЗ-ийн 2010.06.02-ны 3/882 тоотыг хүргүүлсэн байна. Мөн БОАЖ газрын дарга Ч.Уртнасанд П.Цолмон нь 2012 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд 60 оноо авч тэнцэж нөөцийн бүртгэлд байгаа тул Улаан-Уул сумын байгаль хамгаалагчаар томилуулахаар нөөцөөс нэрийг дэвшүүлж байна. Ажилд нь томилж хариу ирүүлнэ үү” гэсэн тоотыг 2013.1.10-ны 1/90 тоотыг ТАСЗ-өөс хүргүүлсэн байна. Одоо П.Цолмон нь Улаан-Уул сумын байгаль хамгаалагчаар /Нягтлан бодогч, Эдийн засагч мэргэжилтэй/ ажиллаж байгаа бөгөөд П.Цолмонг нөөцөөс нэр дэвшүүлэх үед бусад сумдын газрын даамлын ажлын байранд ТАМШ өгч нөөцөд бүртгэгдсэн иргэд цөөнгүй байсан болно.

✚ Их-Уул сумын ЗДТГазрын дарга М.Пүрэв-д “ТАСЗ-ийн шийдвэрээр танай сумын ЗДТГазрын газар тариалан ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтнээр Чимэдийн Оюунбилэгийг томилуулахаар нэр дэвшүүлэн хүргүүлсэн тул томилж хариуг манайд ирүүлнэ үү. МУ-ын төрийн албаны стандартыг хэрэгжүүлж ажиллахыг танд үүрэг болгож байна. ТАСЗ-өөс нэр дэвшүүлсэн хүмүүсийг томилон ажиллуулахгүй бол холбогдох санхүүжилт хийгдэхгүй болно” гэсэн байна.

✚ Сумдын ЗДТГ-ын дарга нарт “ Монгол мал хөтөлбөрийн хүрээнд сумдын ЗДТГ-т шинээр бий болсон 46 ажлын байрыг нөөцөөс хангах арга хэмжээ авч тухайн ажлын байранд бүртгүүлж, ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг илүү хангаж байгаа нэр бүхий иргэдийг ажилд нь томилуулахаар нэрийг нь дэвшүүлж хүргүүлж байна. Иймд та нөхөд нэр дэвшигдэн хүргэгдсэн иргэдийг ажилд томилон дүнг ТАСЗ-д ирүүлнэ үү” гэжээ.

✚ Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Лхагважавд “ Түнэл сумын Нийгмийн даатгалын байцаагчийн ажилд Ж.Гантуяаг нөөцөөс томилуулахаар нэр

¹⁴ ТАЗ 2009 оны 99 дүгээр тогтоолын 6.2.5. иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай холбогдох Зөвлөлийн шийдвэр гармагц уг шийдвэр, “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын хуудас”-ыг тухайн байгууллагад албан ёсоор шилжүүлэх;

дэвшүүлсэн тухай аймгийн ТАСЗ-ийн тогтоолыг хүргүүлж байна. Ажилд нь томилж, манайд хариуг ирүүлнэ үү” гэсэн албан бичиг хүргүүлжээ.

✚ БОАЖГазрын дарга Ч.Уртнасанд “Шинэ-Идэр сумын Байгаль хамгаалагчийн ажлын байранд ТАМШ-нд орж тэнцэн нөөцөд байгаа Э.Цогтсайханыг Т.Энхжаргалын жирэмсний амралтын хугацаанд ажиллуулахаар нөөцөөс нэрийг нь дэвшүүлэн хүргүүлж байна. Ажилд нь томилон хариу ирүүлнэ үү” гэснээр Э.Цогтсайханыг томилон ажиллуулж байна¹⁵.

✚ Аймгийн засаг даргын эрхлэх хүрээний агентлагын дарга нарт “Танай байгууллагын захиалгаар зарим ажлын байрыг нөөцөөс хангахаар нэр дэвшүүлсэн ТАСЗ-ийн 2011.05.19-ний өдрийн 13-р тогтоолд холбогдох материалыг хүргүүлж байна. Дурьдсан хугацаанд нэр дэвшсэн иргэдийг ажилд нь томилж, хариу ирүүлье”

✚ Алаг-Эрдэнэ сумын засаг дарга Ч.Хуншагайд: “ТА-нд анх орох иргэдийн нөөцөд бүртгэлтэй байгаа тул Ганзоригийн Мэндсайханыг танай сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтны ажлын байранд томилуулахаар нэр дэвшүүлсэн аймгийн ТАСЗ-ийн 2010 оны 09 дүгээр тогтоол хүргүүлж байна. Тухайн ажлын байранд нь Г.Мэндсайханыг томилж, шийдвэрийнхээ хувийг аймгийн ТАСЗ-д ирүүлнэ үү” гэсэн албан бичгийг дээрх ажил олгогч этгээдүүдэд тус тус хүргүүлжээ.

✚ ТАСЗ-ийн 2012 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлд: Г.Төмөрбаатар нь зарим сумд нөөцөөс нэр дэвшүүлсэн иргэдийг тухайн ажилд томилохгүй байна. Иймд зарим сумдын ЗДТГ-ын дарга, Засаг дарга нарт хариуцлага тооцох саналыг аймгийн Засаг даргад уламжлах нь зүйтэй байна гэжээ.

УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 41-д зааснаар сонгон шалгаруулалтад тэнцсэн төрийн жинхэнэ албанд анх орох иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 17.3-т заасан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгсөнд тооцно” гэсэн үндэслэлээр ажлын туршлагагүй иргэнийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд оруулан нөөцөд бүртгэж улмаар сул ажлын байранд нөөцөөс нэрийг дэвшүүлэн томилуулж байна. Тус журмын 11,12,13-т заасан Удирдах албан тушаалын сул орон тооны захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт ТАСЗ-д ирүүлэхдээ албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалын зорилго, зорилт, гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлага болон дараах шалгуурыг хангасан байдлыг тусгасан байна. Үүнд:

- Тухайн албан тушаалыг эрхлэг мэдлэг
- Боловсролын түвшин

¹⁵ МУ дээд шүүхийн 2010 оны 08 дугаар тогтоол “Ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулж, албан тушаалын сул орон тоог нөхөх эрх нь зөвхөн тухайн албан тушаалтныг томилох эрх бүхий албан тушаалтанд хамааралтай”

- Мэргэжил
- Ажлын туршлага, мэргэшлийн үр чавдар гэжээ.

Иймд удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд орохоор бүртгүүлж байгаа иргэнийг дээрх шалгуурыг хангасан байдлыг зайлшгүй харгалзах шаардлагатай болсоныг харуулж байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5:

№	Овог нэр	Нэр дэвшүүлсэн албан тушаал	Сонгон шалгаруулалтанд орсон ажлын байр
1	Н.Цасчихэр	Цэцэрлэг сум БОХ улсын байцаагч	Тариалан сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
2	Н.Нямбаяр	НХҮХэлтэст Мөрөн сум хариуцсан мэргэжилтэн	Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
3	М.Энхтайван	Жаргалант сумын ДАЭССХ мэргэжилтэн	Эрдэнэбулган сумын ЗДТГазрын даргын сонгон шалгаруулалт
4	Х.Баянзул	ХҮХэлтэс мэргэжилтэн	Цагаан-Уул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт
5	Э.Хандмаа	ТЗУХэлтэст мэргэжилтэн	Ханх сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
6	Б.Азбилэг	Аймгийн НХХэлтсийн мэргэжилтэн	Тариалан сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт /2012 он/
7	У.Эрдэнэзаяа	Мөрөн сумын нийгмийн ажилтан	Тариалан сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт /2012 он/
8	Б.Нямжав	БОАЖГазрын мэргэжилтэн	Ренчинлхүмбэ сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
9	О.Даваадалай	НДХэлтэс НДбайцаагч	2012 оны 9-р сар 17-р тогтоол Ренчинлхүмбэ сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
10	Д.Ичинхорлоо	НДХэлтэс НДбайцаагч	2012 оны 9-р сар 17-р тогтоол Ренчинлхүмбэ сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
11	А.Лхагвасүрэн	Рашаант сумын нийгмийн ажилтан	Цэцэрлэг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтанд орсон байна.
12	Э.Уугантуяа	Хөдөлмөрийн хэлтэс мэргэжилтэн	Их-Уул сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт
13	М.Соёлмаа	Хөдөлмөрийн хэлтэс мэргэжилтэн	Ренчинлхүмбэ сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
14	О.Золзаяа	Ханх сумын ДАЭЗСС	Түнэл сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон

		хариуцсан мэргэжилтэн	шалгаруулалт
15	Т.Жавзандулам	Ханх сумын нийгмийн ажилтан	Эрдэнэбулган сумын ЗДТГ даргын сонгон шалгаруулалт
16	Х.Гэрэлтуяа	Эрдэнэбулган сумын ДАЭЗСС хариуцсан мэргэжилтэн	Цагаан-Үүр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалт /2012 он/

Хүснэгтээс харахад: Удирдах ажилтны мэргэшлийн шалгалтанд орох иргэдийг ТАСЗ-ийн гишүүд мэдэн будилж ажлын туршлага, мэргэшлийн үр чавдарыг харгалзахгүй сонгон шалгаруулалтанд оруулж нөөцөд бүртгэж байна. Дээрх заалтын дагуу төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгсөнд тооцох гэснээр дулдуйдан дээрх иргэдийг тухайн ажилд томилуулсан байна.

- 2010 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ЗДТГ-ын “Бэлчээр газар тариалан, ЖДҮ үйлчилгээ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн”-ий ажлын байранд шалгалт өгч тэнцэн 1-т зогссон Цэрэнжамц овогтой Хишигбаярыг нөөцөд бүртгэн туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалтад бүртгэсэн Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарчээ. Гэтэл Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоол “Мэргэшлийн шалгалтанд тэнцэн хамгийн өндөр оноо авсан иргэдийг тухайн ажлын байранд нь томилуулахаар нэр дэвшүүлэх” тухай тус сумын ЗДТГ-ын тухайн ажлын байранд Зоригт овогтой Наранцэцэг гэдэг иргэний нэрийг дэвшүүлсэн байна. Тус ажлын байранд З.Наранцэцэг томилогдон ажиллаж байна. Гэвч энэхүү иргэн нь мөн өдөр тус сумын МАА-н үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтний /өөр ажлын байр/ ажлын байранд шалгалт өгч нөөцөд 2-рт бүртгэгдсэн байна.

- Банзайрагчаа овогтой Баасансүрэн нь 2012 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтанд Цагааннуур сумын дотоод ажил, эрх зүй, сургалт, сурталчилгаа хариуцсан туслах түшмэлийн сул ажлын байранд шалгалт өгөн нөөцөд бүртгэгдсэн байна. Гэтэл ТАСЗ-ийн 2012 оны 18 дугаар тогтоолоор Ханх сумын ЗДТГ-ын даргын ажлын байранд Б.Баасансүрэнгийн нэрийг дэвшүүлэн хүргүүлсэн нь туслах түшмэлийн ангиллаас ахлах түшмэлийн ангилал буюу удирдах албан тушаалын ангилалд дэвшүүлсэн зэрэг нь мэргэшлийн шалгалт өгсөн онооны дараалал, үр чадвар, шалгалт өгсөн ажлын байр, тухайн томилогдох албан тушаалын ангилал, мэргэжил зэргийг харгалзан үзээгүй нэр дэвшүүлсэн байна. Б.Баасансүрэн нь 2012 оны 9 дүгээр сард зохион байгуулсан Ханх сумын ЗДТГ-ын даргын ажлын байранд өрсөлдөн 1-т жагссан байна.

- Цэцэрлэг сумын ЗДТГ-ын дарга Н.Пүрэвсүрэнд Танай сумын төрийн сангийн төлөөлөгчөөр П.Уранчимэгийг Төрийн албаны тухай хууль болон бусад хууль эрх

зүйн актын хүрээнд уг ажлын байранд томилуулахаар нэр дэвшүүлсэн. П.Уранчимэг нь төрийн сангийн чиглэлээр Мөрөн сумын ЗДТГ-т дадлага хийж энэ ажлын чиглэлээр зохих мэдлэгтэй болсон. Иймд аймгийн ТАСЗ-ийн шийдвэрийг хүндэтгэн үзэж П.Уранчимэгийг тухайн ажилд нь томилохыг мэдэгдье. */ТАСЗ-ийн 2013 оны 5 дугаар сарын 30-ны 3/1247 тоот албан бичиг/*. Танай сумын ЗДТГ-ын төрийн сангийн төлөөлөгчийн ажлын байранд аймгийн ТАСЗ-ийн шийдвэрээр Пүрэвсүрэнгийн Уранчимэгийг томилуулахаар нөөцөөс нэр дэвшүүлэн хүргүүлсэн боловч та төрийн албаны стандартыг хэрэгжүүлэхгүй, удирдах байгууллагын шийдвэрийг үл ойшоон өдий хүрлээ. Иймд та аймгийн ТАСЗ-ийн шийдвэрийг хүндэтгэн үзэж төрийн захиргааны жинхэнэ албаны сул орон тоог нөхөх шаардлагатай байгааг танд уламжилъя. Төрийн албаны салбар зөвлөлийн шийдвэрийг эс биелүүлвэл холбогдох арга хэмжээг авах болно. */ТАСЗ-ийн 2013 оны 9 дүгээр сарын 10-ны 3/1976 тоот албан бичиг/*

Мөн аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга П.Ариунбатад Пүрэвсүрэнгийн Уранчимэг нь 2012 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн 60 оноо авч, аймгийн ТАСЗ-ийн 2012 оны 09 дүгээр сарын 27-ны 17 дугаар тогтоолоор баталгаажиж удирдах ажилтны нөөцийн бүртгэлд байгаа болохыг тодорхойлов гэсэн албан бичгийг хүргүүлжээ. */ТАСЗ-ийн 2013 оны 1 дүгээр сарын 29-ний 3/228/*

ТАСЗ-ийн нөөцөөс нэр дэвшүүлэн томилуулсан нэр бүхий иргэдээс тухайн ажлын байрны зорилго чиглэлд хамааралгүй мэргэжлийн иргэд ч цөөнгүй байна.

✚ Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн Э.Уугантуяа, Б.Баярмаа, М.Батчимэг нарын ажлын байранд тавих шаардлага нь эдийн засаг нийгэм судлал, нийгмийн ажилтан, бизнесийн удирдлага, менежментийн мэргэжилтэй гэж заасан атал аялал жуулчлалын менежмент, төрийн захиргаа удирдлагын мэргэжилтэй зэрэг дээрх нэр бүхий иргэдийг нөөцөөс нэр дэвшүүлэн томилуулсан нь ТАСЗ-ийн мөн л *заль* бололтой. Э.Уугантуяа төрийн албанд ажиллаагүй байтал тус хэлтсийн ахлах мэргэжилтнээр томилуулахаар нэрийг дэвшүүлсэн байна.

✚ Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтыг ТАСЗ-ийн тогтоолоор баталгаажуулан ТАЗ-д хүргүүлсэн хэдийч зарим иргэдийг баталгаажуулаагүй хассан байна. **Эдгээр нь** : ТАСЗ-ийн 2009 оны 10 дугаар тогтоолд: Заяабаяр-Шинэ-Идэр сумын төрийн сангийн төлөөлөгч, Х.Отгонбаярыг-ХХҮХэлтэс мэргэжилтэн, Д.Бямбацогтыг-Арбулаг сумын ЗДТГазарт нийгмийн даатгалын байцаагчийн нөөцөд бүртгэсэн зэрэг байна. */Хавсралт №1 ээс харна уу/*

Тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа иргэдийн судалгааг¹⁶ томилох эрх бүхий этгээдэд хүргүүлэх бус зөвхөн ганцхан иргэний нэрийг дэвшүүлж тэдгээрийн сонгож авах эрхийг хязгаарлаад байна. Мөн ТАСЗ-ийн **башир аргаар** иргэнийг ямар ажилд, хаана, хэзээ томилох, чөлөөлөх эсэхийг шийдвэрлэж байгаа бөгөөд ажил олгогчид үүнийг гардан гүйцэтгэж байна.

2.4. Зэрэг дэвийн үнэ цэнийг алдагдуулсан байна.

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1¹⁷, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-аар зэрэг дэв олгох харилцааг журамлан зохицуулж байгаа ба нэгж, байгууллагын саналыг үндэслэн Төрийн албаны салбар зөвлөл нь журамд¹⁸ заасны дагуу албан тушаалын зэрэг дэв, цол олгох талаар аймгийн Засаг даргад санал хүргүүлэн аймгийн засаг даргын захирамжаар албан тушаалтнуудад зэрэг дэв олгож байна.

УИХ-ын тогтоолд заасан хугацааг харгалзалгүй зэрэг дэв олгуулахаар ажил олгогчоос ирүүлсэн саналыг үндэслэн зэрэг дэвийг хавтгайруулан олгосон байна. Тухайлбал:

- ✚ Зарим байгууллагын албан хаагчид жил бүр зэрэг дэвээ нэмүүлэх, алгасуулан нэмүүлж байгаа нь хэвийн үзэгдэл болоод байна. Гэхдээ тэдгээр албан хаагчид төрийн захиргааны ажилд нарийн мэргэшин, онцгой үр бүтээлтэй ажилласан гэхэд эргэлзээтэй, нотлох баримтгүй гагцхүү үр дүнгийн гэрээний үнэлгээний дүн төдий л байна¹⁹. /Хавсралт №2-с харна уу/
- ✚ Аймгийн засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн Б-09 дүгээр захирамж “Зэрэг дэвийн нэмэгдэл олгох”-ийн хавсралтад БОАЖГ-ын мэргэжилтэн А.Батболд нь /туслах түшмэлийн ангилал/ төрд болон тухайн албанд 1 жил 6 сар ажилласан байхад гутгаар зэрэг олгосон байна.

¹⁶ ТАСЗ-ын 2009 оны 99 дүгээр тогтоолын 6.2.3. энэхүү журмын 2.1.1-2.1.4-т заасан төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн бүртгэлд байгаа болон мөн журмын 2.2.1-2.2.4-т заасан төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэлд байгаа иргэдээс тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа иргэдийн мөн журмын 1 буюу 2 дугаар хавсралтын дагуу гаргасан судалгааг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

¹⁷ 20.1. Төрийн жинхэнэ тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

¹⁸ 2.1.13. Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгуулах асуудлаар Төрийн албаны зөвлөлд, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэв, цол олгох талаар эрх бүхий этгээдэд тус тус санал өгөх;

¹⁹ УИХ-ын 1995 оны 73 дугаар тогтоолын 10-т Төрийн захиргааны ажилд нарийн мэргэшин, онцгой үр бүтээлтэй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид энэ журмын 6 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө зэрэг дэв олгож болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл зэрэг дэвийг алгасуулан олгож болно.

- ✚ 2012 онд Мөрөн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ш.Энхтуулийн зэрэг дэв олгуулах санал ТАСЗ-д шууд ирсэнтэй холбогдуулан Мөрөн сумын ЗДТГ-ын дарга Ш.Янжиндулам хэлэхдээ:²⁰.... “Ш.Энхтуул нь үр дүнгийн гэрээ байгуулаагүй, юу ч хийдэггүй, ажил хийдэггүй, тийм сайн хүн юм бол эндээ ав, ямар бичгээр зэрэг дэв олгуулахаар ирсэн юм тэр албан бичгийг үзмээр байна” гэжээ. 2013 оны Б-09 дүгээр захирамжаар Туслах түшмэлийн дөтгөөр зэрэг авсан байна.
- ✚ Мөн зарим байгууллагын албан хаагчид жил бүр зэрэг дэвээ нэмүүлж байгааг дурьдах байна. Жишээлбэл: Нийгмийн даатгалын байцаагч Н.Таванзул, Б.Цэнд-Аюуш, ХТТ-ын мэргэжилтэн Д.Мөнгөнтуяа, Ч.Дашбаяр, Г.Гандэлгэр, Мөрөн сумын мэргэжилтэн Б.Дугараа зэрэг байна.

Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгохдоо төрийн албанд нийт ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, **мэргэшлийн түвшингийн** үнэлгээг үндэслэн олгох ёстой атал ийм зөрчил гарсаар байна.

Дээрх байдлаас харахад албан хаагч нь удирдлагаараа дамждаагүй, өөрийн хүсэлтээр ТАСЗ-д шууд материалаа ирүүлдэг тохиолдол ч гарсан байна.

2.5. Эрх бүхий албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, томилгоотой холбоотой өргөдөл, гомдол гаргасан иргэд цөөнгүй байна.

Төрийн албаны Салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон сонгон шалгаруулалт, ажлын байрны маргаан болон бусад асуудлаар иргэн, байгууллага нь өргөдөл, гомдол гаргах эрхийг хуулиар олгосон бөгөөд 2009 оноос өнөөдрийг хүртэл ТАСЗ-д ирсэн ажлын байртай холбоотой өргөдлүүдээс дурьдвал:

✚ Иргэн Б.Саран нь 2009 оны 12-р сард зохион явуулсан мэргэжлийн шалгалтанд Тариалан сумын ЗДТГазрын “Дотоод ажил эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн”-ий сонгон шалгаруулалтанд орж хамгийн өндөр оноо авсан боловч тухайн ажлын байрны сул орон тоонд томилогдоогүй гэж ТАСЗ-д ирүүлсэн өргөдөлдөө дурьджээ. Мөн Б.Саран энэхүү маргаанаа шүүхээр /ажилд томилуулахаар/ шийдвэрлүүлсэн ч эрх бүхий албан тушаалтан нь томилогүй тухайн иргэнийг мохоосон байна. Тус ажлын байрны сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн боловч оноогоороо 10-т жагссан Д.Баасанбатыг үндэслэлгүйгээр томилсон байна.

✚ ТАСЗ-д ирүүлсэн Ч.Бадарчийн өргөдөлд дурьдсанаар: Бадарчийг аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2009.03.11-ний өдөр гаргасан 17 тоот шийдвэрээр аймгийн БСГ-ын санхүүгийн дотоод хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтний ажилд эргүүлэн тогтоосон бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх шүүгчийн захирамж гарч, ШШГА-аас ажиллагаа явуулсны дагуу 2009.11.19-ний

²⁰ ТАСЗ-ийн 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэл

өдөр /8 сарын дараа/ БСГ-ын дарга Н.Баатар-Очир “Ажилд эргүүлэн томилох тухай” 73 тоот тушаал гаргаж ШШГА-нд өгсөн боловч тушаал гарсан тухай надад танилцуулаагүй гэжээ. Гэтэл дарга Н.Баатар-Очир 2009.12.11-нд “Ажлаас халах тухай” 84 тоот тушаал гаргаад надад өгөлгүй бичиг хэрэгт өгчихсөн байсныг дам хүнээс сонсч 2009.12.28-нд бичиг хэргийн ажилтнаас гуйж авсан бөгөөд уг тушаалд Төрийн албаны тухай хуулийн 26.1.3-ыг үндэслэсэн гэжээ. Мөн өргөдөлдөө дурьдахдаа ажил хүлээлцээгүй атал ажлаас халсан нь хуульд нийцэхгүй гэсэн байна. ТАСЗ –ийн хурлаар авч хэлэлцээд шийдвэр гаргах боломжгүй гэж хариу хүргүүлсэн нь ямар үндэслэлээр шийдвэрлэсэн нь тодорхой бус байна.

Иргэн Д.Батчулуун нь аймгийн Аудитын газар болон ТАСЗ гаргасан өргөдөлдөө: “Миний бие ХХААЖДҮГ-ын даргаар 2008-2010 онуудад ажиллаж байсан. 2008.09.21-ний ТАСЗ-өөс зохион байгуулсан мэргэшлийн шалгалтанд /тухайн албандаа/ орж нөөцөд бүртгэгдэж, нөөцөд байгаа. Өмнө ажиллаж байсан дарга Б.Наранчулуун нь буруу халагдсан гэх үндэслэлээр шүүхийн шийдвэр гарсан тул ажлаасаа чөлөөлөгдсөн. Харин одоо шинээр илэрсэн нөхцөл байдал үүсч миний бие энэ албанд томилогдох нөхцөл бүрэн бүрдсэн тул дүгнэлт гарган томилж өгнө үү” гэжээ. Аймгийн ТАСЗ-өөр авч хэлэлцэхдээ: Бидний шийдэх асуудал биш байна. Хууль хяналтын байгууллагаар асуудлаа шийдүүлэх хэрэгтэй, *шийдвэрлэх боломжгүй* хэмээн хариу хүргүүлжээ. Тус ажлын байранд 2008.09.21-нд Б.Дамдинсүрэн, Я.Эрхэмбаяр, Б.Нарантуяа, М.Батбаяр, Д.Батчулуун нар мэргэшлийн шалгалтанд орж Я.Эрхэмбаяр 50.6 оноо, Д.Батчулуун 47 оноо авч бусад нь авах ёстой оноондоо хүрээгүй байна. Я.Эрхэмбаяр нь өөрийн хүсэлтээр ҮДББОБЗХ-тээ мэргэжилтнээр үргэлжлүүлэн үлджээ. Аймгийн засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн Б-22 дугаар захирамжаар Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын даргаар Б.Галбадрахыг томилон ажиллуулж байна.

Жаргал сумын төрийн сангийн төлөөлөгчийн сул ажлын байранд нөөцөд бүртгэгдсэн Л.Баасансүрэн, Ч.Мөнхжаргал нарыг тус тус томилуулахаар ТАСЗ-өөс нэрийг дэвшүүлж Мөнхжаргалыг /ТАСЗ-д 2010 оны 6 дугаар сард өргөдөл ирүүлсэн/ томилсон байна. Мөнхжаргал нь ажлаас чөлөөлөгдсний дагуу тус сумын засаг даргын Тамгын газрын даргын 2012 оны 05 дугаар сарын 01-ний Б/12 тоот тушаалаар ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзэж Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр төрийн албаны шалгалтанд ороогүй Ш.Ганжамьянг томилсон байна. Энэ хугацаанд иргэн Б.Саранцэцэг нь ТАСЗөвлөлд 2012 оны 2 дугаар сард ирүүлсэн өргөдөлдөө: Жаргалант сумын төрийн сангийн төлөөлөгчийн сул ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэхээр хүсэлт гаргасны дагуу ТАСЗөвлөл нь: 2012 оны 02 дугаар сарын 28 ны 3/276 тоот албан бичгээр “Та сумандаа төсвийн байгууллагын няглан бодогчоор ажиллаж байгаагийн зэрэгцээ, танай сумын удирдлага өөр ажилд шилжүүлэх боломжгүйг мэдэгдсэн тул таныг тус сумын ЗДТГ-ын төрийн сангийн төлөөлөгчийн ажлын байранд нөөцөөс нэр дэвшүүлэх боломжгүйг мэдэгдэе” гэсэн хариуг өгсөн байна. Б.Саранцэцэгийн

өргөдлийн хариуг ТАСЗ-өөс ирүүлэхдээ: “сумын төрийн сангийн төлөөлөгчийн сул орон тоонд нөөцөөс, эсхүл бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн авах замаар, ийм боломжгүй гэж үзвэл сул ажлын байрыг нийтэд зарлуулах замаар нөхөх эсэхийг Засаг даргын Тамгын газрын дарга шийдвэрлэх бүрэн эрхтэй гэсэн байна.

ТАСЗ-ийн хуралдааны тэмдэглэлд: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд хэлэхдээ Б.Саранцэцэг манайд ажиллаж байсан, сайн ажиллаж байсан гэж тэмдэглэгдсэн байна. Гэтэл ТАСЗ-өөс тус ажлын байрыг нөөцөөс хангах талаар шийдвэр гаргасан нь *намчирхаад байна уу гэлтэй*. Иргэн Б.Саранцэцэг нь 2010 оны 10 дугаар сард Арбулаг сумын Татварын улсын байцаагчийн сул ажлын байрны сонгон шалгаруулалтанд орж тэнцэж нөөцөд бүртгэгдсэн бөгөөд ТАТ хуулийн 17.1²¹-д заасан заалтыг хангаж байсан байна. 2011 оны 11 дүгээр сард аймгийн Татварын хэлтсийн татварын орлого бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтний сонгон шалгаруулалтанд орж 28-д /хамгийн бага оноотой/ Лхагвасүрэнгийн Одгэрэлийг 2012 оны 4 дүгээр сарын 13-ны 3/547 тоотойр Жаргалант сумын төрийн сангийн төлөөлөгчийн сул ажлын байранд томилуулахаар нэрийг дэвшүүлэн томилж хариуг ирүүлнэ үү гэжээ. Одгэрэл нь тус сумын оршин суугч биш бөгөөд хэрэв тус албан тушаалд томилогдвол тогтвор суурьшилтай ажиллах эсэх талаар эргэлзээтэй юм.



²¹17.1. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.

ТАСЗ иргэдээс ирүүлсэн зарим өргөдлийг холбогдох хууль, эрхийн дагуу оновчтой шийдвэрлэхгүй, улмаар ТАЗ болон хуулийн байгууллагад хандаж шийдүүлэх зэргээр иргэдийг чирэгдүүлэх, эсвэл иргэдийн өргөдөлд нэг талыг барьж шийдвэр гаргадаг байна уу гэлтэй.

2.6 Шалгуулагчдаас хураан авч буй мөнгөн төлбөрийн зарцуулалт хяналтгүй байна.

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журамд зааснаар мэргэшлийн шалгалттай холбоотой гарах зардлыг шалгуулагч иргэн өөрөө хариуцах талаар заасан бөгөөд шалгалтын бүртгэлийн хураамжийг нэг иргэнээс 1500-10000 /хооронд/ төгрөгөөр тус тус тооцон бэлнээр хураан авсан байна.

Шалгуулагчдаас авч буй мөнгийг бэлнээр хураан зарцуулсан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7.1²², 7.4²³, 8.3²⁴ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Түүнчлэн Сангийн сайдын 2010 онд баталсан “Төсвийн байгууллагад мөрдөгдөх кассын ажиллагааны журам”-ын 2.8-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч болно. Энэхүү орлогыг хүлээн авсан тохиолдолд төсвийн байгууллага түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд дараагийн ажлын өдөртөө багтаан өөрийн Төрийн сангийн бүртгэлийн дансанд шилжүүлнэ” хэмээх заалтыг зөрчиж данс бүртгэлд тусгалгүй хоолны зардал, бичиг хэргийн зардал, томилолтын зардал болон урамшуулалд зарцуулсан байна.

Аудитын хугацаанд ТАСЗ-өөс ТАМШ-д орсон иргэдийн нийт тоо, бусад мэдээллийг ирүүлэхийг шаардсан боловч үнэн зөв мэдээллийг ирүүлэхгүй нэлээн хойрог хандсаны эцэст бодит мэдээллийг ирүүлсэнийг дурьдах байна. ТАСЗ-өөс анх ирүүлсэн судалгааг хавсралт №3-р харуулав.

²² 7.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

²³ 7.4. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ.

²⁴ 8.3. Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараахь дарааллаар гүйцэтгэнэ

Мэрэгшлийн шалгалт зохион байгуулсан шалгалтын төлбөр

Хүснэгт № 6

Он	Шалгалтын төлбөр	ТАСЗ-өөс ирүүлсэн баримт	Үнээс хоолонд зарцуулсан дүн	Зөрүү
Анх орох иргэний мэргэшлийн шалгалт				
2009	4043900	3483050	1343870	560850
2010	1914000	1851000	659600	63000
2011	1896000	1486100	229650	409900
2012	990000	1359420	541600	-369420
2013	2964000	2791400	863900	172600
Зөрүү	836930			
Удирдах ажилтаны мэргэшлийн шалгалт				
2009	0	0	0	
2010	0	0	0	
2011	320000	240000	119300	80000
2012	1080000	1010000	377600	70000
2013	490000	282000	118800	208000
Зөрүү	358000			
Үлдэгдэл бэлэн мөнгө	172.600			
Нийт зөрүү	1.022.330			
Нийт цугларсан мөнгөн төлбөр /байвал зохих/		13.697.900		
Хоолонд зарцуулсан нийт дүн			4.254.320	
Төлбөрийн акт тогтоох дүн	1,022,330			

Хүснэгт № 6-аас харахад: 15 удаагийн шалгалтанд нийт 13.697.900 төгрөг хураасан ба 30 хувь буюу 4.254.320 төгрөгийг хоолонд зарцуулсан байна.

2013 оны 10 дугаар сард зохион байгуулсан шалгалтад 2.791.400 төгрөг зарцуулснаас хоолонд 863.900 төгрөгийг хяналтгүй дураараа зарцуулсан байна. Ийнхүү 172.600 төгрөгний үлдэгдэл бэлнээр байна. 2009-2013 оны байдлаар ТАСЗ-өөс ирүүлсэн шалгалтын зарцуулалтын тайлангаас харахад нийт 1.022330 /нэг сая хорин хоёр мянга гурван зуун гучин төгрөг/ төгрөгийг хэрхэн юунд зарцуулсан нь тодорхой бус байгаа тул төлбөрийн акт тогтоон бэлэн байгаа 172600 төгрөгийг аймгийн ЗДТГ-ын төрийн сан дахь дансанд төвлөрүүлэхээр шийдвэрлэв.

Шалгалтанд тэнцээгүй иргэдэд мөнгийг буцаан олгодог гэсэн тайлбарыг хэлж байсан хэдий ч иргэн Д.Дарамжавын ТАСЗ-д гаргасан өргөдөлд: 2009 оны 5 дугаар сарын 04-05нд явагдсан мэргэшлийн шалгалтын бүртгэлийн хураамж болох 5000 төгрөгийг буцаан авах хүсэлтэй байна. Учир нь тус мэргэшлийн шалгалтанд хугацаа хоцорч ирсэн тул ороогүй, төрөөс үйлчилгээ аваагүй гэдгээ илэрхийлж байсан боловч ТАСЗ-ийн хурлаар 5000 төгрөгийг буцаан олгох боломжгүй гэж шийдвэрлэсэн тухай хуралдааны тэмдэглэлд тэмдэглэгдсэн байна. Эндээс харахад: Шалгалтанд орохоор бүртгүүлсэн нийт иргэдээс хураамж авдаг бөгөөд түүнийгээ буцаан олгодоггүй байна.

2 ДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

- 1. ТАСЗ мэргэшлийн шалгалт өгсөн онооны дараалал, төрийн албаны ерөнхий болон тусгай шаардлага хангасан байдал зэргийг харгалзахгүй нөөцөөс нэр дэвшүүлдэг, хүсэлт ирүүлсэн нэрийдлээр төрийн албанд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй иргэдээс зөвхөн нэг иргэний нэрийг дэвшүүлэн ажилд томилохоор санал хүргүүлэх, нөөцөд бүртгэлгүй, шалгалт өгөөгүй иргэнийг хуурамч баримт үйлдэн нэр дэвшүүлэн ажил олгогчид хүргүүлэх, төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, төрийн захиргааны албанд нарийн мэргэшсэн зэргийг харгалзалгүй эрх бүхий этгээдэд санал хүргүүлэн зэрэг дэвийг олгуулах, ажлын туршлагыг харгалзахгүй төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах мэргэжлийн шалгалтанд оруулан нөөцөд бүртгэж байгаа зэргээс харахад Төрийн албаны салбар зөвлөл чиг үүргээ хангалтгүй биелүүлснийг харуулж байна.**
- 2. ТЖАМШ-нд орж буй иргэдээс төлбөрийг бэлнээр хураан авч данс бүртгэлд тусгаагүй, хяналтгүй зарцуулдаг байна.**

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах албан тушаалтнуудад доорхи зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Г.Төмөрбаатарт

1. Төрийн албаны салбар зөвлөлийн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хууль зөрчиж томилогдсон албан тушаалтнуудын ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлаж 2014 оны 1 дүгээр улиралд багтаан томилох эрх бүхий этгээдэд өргөн мэдүүлэх
2. Төрийн албанд нөөцөөс нэр дэвшүүлэхдээ тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагад нийцсэн нөөцийн бүртгэлд байгаа иргэний судалгааг гаргаж ажил олгогч этгээдэд хүргүүлэн ажил олгогчоор сонгуулж байх
3. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах шалгалтанд ажлын туршлага, мэргэшлийн үр чадвар гэсэн шаардлагад нийцүүлж байх
4. Ажил олгогч нарт албан тушаал (Ажлын байрны тодорхойлолт)-аар адил чиг үүрэг гүйцэтгэх ажлын байрны захиалгыг ирүүлэхдээ ерөнхий болон тусгай шаардлага адил байх талаар чиглэл өгөх
5. Ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу нөөцөөс хангах болон мэргэшлийн шалгалт явуулах талаарх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй, ил тод нээлттэй байдлаар зохион байгуулж тэгш өрсөлдөх боломжоор хангах
6. УИХ-ын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг баримтлан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлүүлж байх
7. ТЖАМШ-нд орж буй иргэдээс хураан авч буй мөнгөн төлбөрийг бүртгэлд тусгаж, түүний зарцуулалтанд хяналт тавьж байх
8. Хуурамч баримт үйлдэн ажил олгогчид хүргүүлдэг байдлыг таслан зогсоож арга хэмжээ авах
9. Төрийн жинхэнэ албан хаагчийн удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд гарч байгаа зөрчлийг таслан зогсоож хуульд заасан журмын дагуу явуулж олон нийтэд мэдээлж байх.

Аймгийн засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлаг, сумдын засаг дарга нарт

1. Төрийн албаны тухай хуульд заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа, ажлын байрны чиг үүрэгт нийцсэн иргэнийг тухайн ажлын байранд томилон ажиллуулж байх
2. Мэргэшлийн шалгалтанд ороогүй, мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшлийн бэлтгэл, үр чадвар, туршлагын хувьд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, албан тушаалд тавигдах шаардлага нөхцөлийг хангахгүй байгаа иргэдийг ажлаас нь чөлөөлөх эсвэл давтан сургах арга хэмжээ авах
3. Албан тушаал (Ажлын байрны тодорхойлолт)-аар адил чиг үүрэг гүйцэтгэх ажлын байрны захиалгыг хүргүүлэхдээ ТАСЗ-өөс ирүүлсэн чиглэлийг баримтлан ажиллах
4. Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 2 дугаар хавсралт “төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх “илтгэх хуудас”-ын менежерийн тэмдэглэл хэсэгт албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах асуудлын талаар тодорхой бичиж тэмдэглэж байх
5. Батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан үй ажиллагаа явуулах

Аймгийн МХГ-ын дарга Д.Лхагвасүрэн

1. Төрийн захиргааны албан хаагчдын их, дээд сургуульд сурч төгссөн байдал, дипломыг баталгаажуулж дүнг манайд ирүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР
ЗӨВЛӨЛ**
67123, Мөрөн, Хөвсгөл аймаг.
Утас: 70382216

2013. 12. 04 № 3/2641
таний _____ -ны № _____ -т

**АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ОЮУНГЭРЭЛ ТАНАА**

Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны хангалтын үр нөлөөт байдалд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад тайлбар хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГА  Г.ТӨМӨРБААТАР
УХА0115
20

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Тайлангийн төсөлд ирүүлсэн санал	Тайлбар
Үндсэн мэдээлэл	
Аймгийн ЗДТГазар нь МУ-ын 2008 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Аймгийн засаг даргатай ЗДТГ-ын бүтэц, орон тоог зөвшилцөн дотоодын 5-н хэлтэс, 2 тасаг, нэг штабтай тэдгээрт нийт 41 орон тоотойгоор ажиллаж байна.	АЗДТГазрын цалингийн 2013 оны 9 дүгээр сарын цалин тооцож олгосон баримтнаас харахад 38 ТАХ-чид, засаг дарга, ЗД-ын орлогч бүгд 40 байгаа бөгөөд үүнд Цэргийн штабын цэрэг, техникийн нөхөн хангалт, тоо бүртгэл хариуцсан офицер Д.Баясгалан өндөр насны тэтгэвэрт гарсан, Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Х.Энхчимэг чөлөө авсан тул нэрсийн жагсаалтад ороогүй болно. Иймд нэр бүхий ТАХ-ын ажлын байр хэвээр хадгалагдаж, АЗД-ын зөвлөх 1 байна. Бүгд 43 орон тоотой ажиллаж байгаа нь аудитаар тогтоогдсон тул саналыг хүлээн авах боломжгүй.
Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийг 2009 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 23-р тогтоолоор 10 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байгаагаар тайланд бичигджээ.Аймгийн ТАСЗ нь 2003 оны 07-р сарын 10-ны өдрийн 141-р тогтоолоор дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нийлээд 11 хүний бүрэлдхүүнтэй ажиллаж байна.	Тайланд зөвхөн 2009 оны байдлаарх тогтоолоор тусгасан тул 2013 оны 141 дүгээр тогтоолыг тайланд тусгаагүй байсан. Иймд саналын дагуу 2013 оны 141 дүгээр тогтоолоорх өөрчлөлтийг тусгаж ажиллав.
Аймгийн төрийн албан хаагчдын ёс зүйн хороо нь Монгол улсын засгийн газрын 2010 оны 288-р тогтоол,Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12-р сарын 01-ны өдрийн 129-р тогтоол зэргийг үндэслэн аймгийн төрийн албан хаагчдын ёс зүйн хороог Аймгийн ЗДТГ-ын даргын 2011 оны 06-р сарын 16-ны өдрийн А/14-р тушаалаар байгуулж Ёсзүйн хорооны даргаар- Г.Гандэлгэр-ХЗХ-ийн дарга Нарийн бичгийн даргаар-Л.Бямбасүрэн-ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Гишүүнээр-С.Энхзаяа нар ажиллаж байгаа болно.	Тайланд дурьдсанчлан ТА3-ийн 2009 оны 23 дугаар тогтоолоор 10 хүний бүрэлдэхүүнтэй ёсзүйн хороо байгуулан ажилласан байсан нь баримтаар нотлогдох бөгөөд АЗДТГ-ын даргын 2011 оны А/14тоот тушаалаар Ёсзүйн хороо байгуулсан саналыг хүлээж авч тайланд тусгав.
Бүлэг 1	
Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого,аудит хариуцсан мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтонд мэргэшсэн байх гэсэн шаардлага тавиагүй ба энэ талаар тухайн албан тушаалд заавал мэргэшсэн нягтлан бодогч байх шаардлагатай эсэх талаар	Сангийн Яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын даргын 2013 оны 11 дүгээр сарын 13-ны 6/6198 тоот албан бичигт “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд бүртгэлийн мэргэжилтэн заавал мэргэшсэн нягтлан бодогч байна гэсэн шаардлага,

Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Х.Пүрэвсүрэнд хандан 2013.10.31-ний өдрийн 8/2332 албан бичгээр лавлагаа хүсэхэд Сангийн яамны 2013.11.13-ны өдрийн 6/6198 албан бичгээр нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд бүртгэлийн мэргэжилтэн заавал мэргэшсэн нягтлан бодогч байна гэсэн шаардлага шалгуур байхгүй, тус хуулийн 3-р зүйлийн 3.1.7-д зааснаар мэргэжлийн нягтлан бодогчоор тухайн ажлыг гүйцэтгүүлж болно Иймд бүртгэлийн мэргэжилтэнд зориулж байгууллагаас гаргасан ажлын байрны тодорхойлолтонд мэргэшсэн нягтлан бодогч байх шаардлага тавихгүй байж болно гэсэн хариу ирсэн бөгөөд одоо энэ албан тушаалд ажиллаж байгаа Т.Энхтуяа нь улсын байцаагч биш тул Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм хамаарахгүй. Бүртгэлийн мэргэжилтэн улсын байцаагч байна гэсэн ямар нэгэн хуулийн заалт байхгүй болно.	шалгуур байхгүй учраас тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д зааснаар мэргэжлийн нягтлан бодогчоор тухайн ажлыг гүйцэтгүүлж болно” гэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 21.2 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм-д заасан дээрх шаардлагатай нийцэхгүй байна. Иймд саналыг хүлээж авах боломжгүй.
Аймгийн СТСХ-ийн төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн Г.Базар нь 2009 оноос аймгийн Нийгэм халамж үйлчилгээний хэлтэст сум хариуцсан мэргэжилтнээр ажиллаж орон нутгийн хэмжээнд халамжийн сан хариуцан ажиллаж байснаас харахад уг иргэнийг төсөв,төсвийн зардалын талаар туршлагагүй гэж үзэх үндэслэл байхгүй бөгөөд Г. Базарыг Монгол улсын төрийн албаны тухай хуулийн 17-р зүйл, 17.4.3-ыг үндэслэн дээрх албан тушаалд томилсон нь хууль зүйд нийцсэн гэж үзэж байна.	Г.Базарын ажлын байрны тодорхойлолтоор зөвхөн өөрт нь тохирсон шаардлага тавигдсан байгааг харуулбал дараах байдалтай байна. Саналыг хүлээн авах боломжгүй байна.
Тайланд дурдсан Аймгийн Татварын хэлтсийн нэр бүхий төрийн албан хаагчид төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орсон хүмүүс ажиллаж байгаа болно.	Аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Г.Мөнхтулга, Э.Болормаа нар ТАМШ-нд орсон байгаа тул саналыг хүлээн авч тайланд тусгав.
Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн мэргэжилтэн Д.Бямбацогтыг анх ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ц.Жамсранжав ажлаас нь анх чөлөөлсөн бөгөөд шүүхийн шийдвэрээр эргүүлж ажилд нь томилсон. Томилсоноос хойш Д.Бямбацогтыг ажлаас чөлөөлсөн халсан нэг ч эрх зүйн баримт /тушаал,захирамж/ байхгүй . Энэ талаарх бүх баримт бичгийг шалгаж дүгнэлт гаргаж өгөхийг хүсэж байна. Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатар ажиллах хугацаандаа үндэслэлгүйгээр хууль зөрчиж нэг ч хүнийг ажлаас чөлөөлөөгүй болно. Ажлаас албан тушаалтаныг хууль зөрчиж үндэслэлгүй чөлөөлсөн бол хариуцлагаа хүлээе. Харин үндэслэлгүйгээр олон хүнийг ажлаас чөлөөлсөн урьд нь албан тушаал эрхэлж байсан хүмүүст хариуцлага хүлээлгэхийг санал болгож байна.	Аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатар нь аймгийн ЗДТГ-ын ХБХ-ын мэргэжилтэн болох Д.Бямбацогтыг 2010.01.25-ны Б-04, 2011.05.19-ны Б/15, 2011.12.30-ны Б/39 дүгээр тушаалуудаар ажлаас чөлөөлж байсан нь аудитаар тогтоогдсон тул саналыг хүлээж авах боломжгүй.
Бүлэг 2	
Аймгийн БОГ-т мэргэжилтэнээр ажилладаг Б.Батбаяр гэдэг төрийн албан хаагч байхгүй бөгөөд харин Цагааннуур суманд байгаль хамгаалагчаар	Аймгийн ТАСЗ-ийн дарга Г.Төмөрбаатарын 2012.11.28-ны 3/1724 тоотойр “Буянтгогтохын Батбаярыг төрийн албаны мэргэшлийн

/туслах түшмэл ТЗ-2/ ангилалаар БОГ-аас Буянтгогтохын Батбаярыг сум орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарч байгаа ажлын зайлшгүй шаардлагаар томилсон боловч Б.Батбаяр нь өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн бөгөөд одоо уг ажлын байрны захиалгыг Аймгийн ТАСЗ-д албан ёсоор ирүүлсэн болно.	шалгалтанд ортол тухайн ажлын байранд ажиллууж байхыг мэдэгдье” гэсэн албан бичгийг БОАЖГ-ын дарга Ч.Уртнасанд хүргүүлсэн байна. Тайланд Цагааннуур суманд байгаль хамгаалагчаар ажиллаж байснаар өөрчлөв.
Аймгийн ТАСЗ нь төрийн албаны мэргэшлийн шалгалтанд ороогүй нэг ч иргэнийг ажилд томилуулахаар нэр дэвшүүлээгүй,шалгалт өгөөгүй нэг ч иргэнийг нөөцөд бүртгээгүйг хариуцлагатай мэдэгдэхийн хамт Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоолд өөрчлөлт оруулах эрх манайд байдаггүй бөгөөд бүх дүнг интернетэд тавигдсан байдгийг та нөхөд сайн мэднэ.	Аймгийн МХГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын хэлтсийн стандарт чанарын хяналтын улсын байцаагчаар Д.Саруултуул, Энхмаа нарыг удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд орсон хэмээн хуурамч тогтоол үйлдэн тухайн ажилд томилуулсан байсан нь баримтаар нотлогдож байна. Саналыг хүлээж авах боломжгүй.
Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд орох иргэдээс авах мөнгөн хураамжийн хэмжээг тухай бүр нь Шалгалтын төв комисс тогтоож өгдөг бөгөөд цугласан мөнгийг тухайн шалгалтын зардалд зориулан зарцуулдаг болно. Шалгалт бүрийн тооцоог танайд хүргүүлсэн болно.	Ирүүлсэн баримтанд зөрүү гарсан тул төлбөрийн акт тогтоов. Саналыг хүлээн авах боломжгүй байна.
Танай ирүүлсэн саналын хүлээн авах боломжтой асуудлыг тайланд тусгасан бөгөөд зарим асуудал нь хүлээх авах боломжгүй байна. Дээр дурьдагдсан асуудлуудаас бусад нь тайланд ирүүлж байгаа санал биш илэрсэн зөрчилд өгсөн тайлбар байгаа тул хүлээн авах боломжгүй байна.	

Хавсралт № 1

ТАСЗ-ийн 2009 оны 10-р тогтоолоос хасагдсан иргэдийн жагсаалт

№	Овог нэр	Ажлын байр.	Шифр	Авсан оноо
1	Хүрэлгалдангийн Оюунбат	Түнэл сумын МЭҮА-ны байцаагч	100316	63
2	Ганболдын Мөнхзул	АЗДТГ-ын ХБХ-ийн байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	100030	71,2
3	Манчингийн Мөнх-Эрдэнэ	АЗДТГ-ын ХБХ-ийн байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	100024	68,9
4	Равдангийн Чимэддорж	АЗДТГ-ын ХБХ-ийн байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	100080	62,2
5	Хүрэлбаатарын Отгонбаяр	ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн нийгмийн ажилтан	100226	61,6
6	Буриадын Гантуяа	ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн нийгмийн ажилтан	100007	57,5
7	Доржсүрэнгийн Өсөхбаяр	ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн нийгмийн ажилтан	100002	56,5
8	Цэвээннамжилын ОюунЭрдэнэ	ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн нийгмийн ажилтан	100059	56,5
9	Дашзэвэгийн Заяа	ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн нийгмийн ажилтан	100099	55
10	Даваадоржийн Сүхбат	Галт сумын БОХ улсын байцаагч	100414	59,5
11	Эрдэнэбилэгийн Энхтуяа	УТХГ-ын судалгаа, шинжилгээ, мониторинг хариуцсан мэргэжилтэн	100412	55,5
12	Самбуугийн Наранцэцэг	УТХГ-ын орчны бүс сургалт судалгаа хариуцсан мэргэжилтэн	100395	64,1
13	Болдбаатарын Соёлмаа	Улаан-уул сумын байгал хамгаалагч	100439	65,3
14	Цэрэндоржийн Гантуяа	Төмөрбулаг сумын нийгмийн ажилтан	100055	56
15	Дарьсүрэнгийн Ганбат	Бүрэнтогтох сумын нийгмийн ажилтан	100112	56
16	Далайн Мөнхтөр	Рашаант сумын нийгмийн ажилтан	100061	55
17	Лхаасүрэнгийн Баасансүрэн	Жаргалант сумын НД-ын байцаагч	100237	55,9
18	Мандахын Бат-Эрдэнэ	Түнэл сумын НД-ын байцаагч	100260	55,8
19	Ичинхорлоогийн Оюунбилэг	Галт сумын Иргэний бүртгэлийн ажилтан	100448	55
20	Хадбаатарын Нямрагчаа	Төмөрбулаг сумын газрын даамал	100299	60,3
21	Г.Заяабаяр	Шинэ-Идэр сумын төрийн сангийн төлөөлөгч	100467	59,2
22	Д.Бямбацогт	Арбулаг сумын нийгмийн даатгал	100252	61,2

Зэрэг дэвийг хугацаанаас нь өмнө олгосон түүвэр

Хавсралт №2

№	Овог Нэр	Албан тушаалын нэр	Зэрэглэл	Харьяалал	Үр дүнгийн үнэлгээ	Ажилласан жил		Өмнө авсан зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэвийн нэмэгдэл	Тайлбар
						Төрд	Тухайн албанд				
2009 он /54,56/											
1	Б.Бямбасүрэн	Мэргэжилтэн	ТЗ-6	ХХААЖДҮГ	А	2	2	Д/Т	Дөтгөөр	10	Төрийн албанд 5, тухайн албанд 1, нэмэгдэлийг буруу олгосон байх
2	Г.Гандэлгэр	Мэргэжилтэн	ТЗ-5	ХТТ	В	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
3	Б.Адьяа	Ниймгийн ажилтан	ТЗ-3	Арбулаг	А	2	2	Д/Т	Дөтгөөр	10	Төрийн албанд 3, тухайн албанд 1
2010 он /А-131,Б-34/											
4	Д.Цолмонжаргал	Нийгмийн ажилтан	ТЗ-3	Галт	А	2	2	Т/дөтгөөр	Дөтгөөр	10	Төрийн албанд 3, тухайн албанд 1
5	Э.Аззаяа	ХБХ мэргэжилтэн	ТЗ-5	АЗДТГ	А	2	8сар	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
6	Г.Гандэлгэр	Мэргэжилтэн	ТЗ-5	ХТХэлтэс	В	3	2	Д/Т	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1, Мөн зэрэг дэвийг алагсуулан олгосон байна.
7	Р.Отгонцэцэг	Мэргэжилтэн	ТЗ-5	Статистик	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
8	С.Сармандах	Мэргэжилтэн	ТЗ-5	Статистик	А	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
9	Б.Батчимэг	Мэргэжилтэн	ТЗ-7	ЭМГ	А	5	5	А/Т дөтгөөр	Гутгаар	22	Төрийн албанд 7, тухайн албанд 1

10	Б.Ундрах	Мэргэжилтэн	ТЗ-5	АЗДТГ	А	2	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
11	Н.Шинэбаяр	Мэргэжилтэн	ТЗ-5	АЗДТГ	А	1	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
12	Н.Таванзул	Байцаагч	ТЗ-5	НДХ	В	1	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
13	Б.Гантулга	Байцаагч	ТЗ-5	Арбулаг НДБ	В	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
14	Д.Оюунчимэг	Байцаагч	ТЗ-5	Ханх НД	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
15	Н.Янжинлхам	Байцаагч	ТЗ-5	Цагааннуур НД	В	3	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
16	Д.Эрдэнэзул	Байцаагч	ТЗ-5	Цагаан-Уул НД	В	1	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
17	Т.Мөнхбаяр	Дотоод ажил	ТЗ-3	Цагаан-Уул	А	1.1	1.1	Т/Т	Дөтгөөр	10	Төрийн албанд 3, тухайн албанд 1
18	Г.Энхбаяр	Мэргэжилтэн	ТЗ-5	АЗДТГ	В	1	1.1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
2011 он											
19	Д.Дуламсүрэн	Мэргэжилтэн	ТЗ-5	БОАЖГ	В	3	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
20	Б.Хандармаа	Мэргэжилтэн	ТЗ-5	БОАЖГ	В	3	2	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
21	Г.Баттулга	Албаны дарга	ТЗ-7	ХХААЖДҮГ	В	4	4	А/Т дөтгөөр	Гутгаар	22	Төрийн албанд 7, тухайн албанд 1
22	Б.Бямбасүрэн	Мэргэжилтэн	ТЗ-5	ХХААЖДҮГ	В	4	4	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
23	У.Мэргэнжаргал	ТБайцаагч	ТЗ-5	Арбулаг	В	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
24	Д.Бямбацогт	Нийгмийн ажилтан	ТЗ-3	Арбулаг	В	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 3, тухайн албанд 1

25	Д.Хишигсайхан	БОХУБ	T3-6	Төмөрбулаг	B	4	4	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
26	В.Түвшинжаргал	ЗДТГдарга	T3-7	Галт	A	2	2	A/Т	Дөтгөөр	20	Төрийн албанд 7, тухайн албанд 1
27	З.Соёлмаа	БОХУБ	T3-6	Мөрөн	B	4	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
28	Н.Янжинлхам	Байцаагч	T3-5	Цагаан нуур	B	2	2	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
29	Н.Таванзул	Байцаагч	T3-5	НДХ	A	2	2	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
30	Д.Эрдэнэзул	Байцаагч	T3-5	Цагаан-Уул НД	B	2	2	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
31	Ч.Тунгалаг	ЭМД байцаагч	T3-5	Тариалан	A	4	4	Д/Т дэд	Тэргүүн	20	Төрийн албанд 5, тухайн албанд 1
32	Б.Гантулга	НДбайцаагч	T3-5	Арбулаг	A	3	3	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
33	Д.Оюунчимэг	НДбайцаагч	T3-5	Ханх НД	B	4	4	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
2012 он /A/15/											
34	Б.Ганзориг	Мэргэжилтэн	T3-5	ГХБХБГ	A	4	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
35	С.Энхзаяа	Мэргэжилтэн	T3-5	ХЗХ	B	4.1	4.1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
36	Г.Энхбаяр	Мэргэжилтэн	T3-5	ХБХ	A	3	3	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
37	Б.Энхзул	Мэргэжилтэн	T3-5	ХБХ	B	3	3	Д/Т дөтгөөр	Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
38	О.Энхтүвшин	Мэргэжилтэн	T3-7	Ханх	A	4	4	A/Т дөтгөөр	Гутгаар	22	Төрийн албанд 7, тухайн албанд 1
39	Н.Билэгдэмбэрэл	Мэргэжилтэн	T3-6	Галт	A	4	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
40	В.Түвшинжаргал	ЗДТГдарга	T3-7	Галт	A	3	3	A/Т дөтгөөр	Дэд	23	Төрийн албанд 7, тухайн албанд 1

41	М.Болормаа	Мэргэжилтэн	T3-5	БОАЖГ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
42	Б.Гантуяа	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
43	Г.Оюун-Эрдэнэ	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
44	Б.Бямбаа	Мэргэжилтэн	T3-6	Бүрэнтогтох	В	2	2	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
45	Ц.Баярцэнгэл	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
46	Ч.Төгсжаргал	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
47	Б.Азбилэг	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
48	Г.Базар	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
49	С.Ренчинханд	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
50	Ц.Оюун-Эрдэнэ	Мэргэжилтэн	T3-5	ХХҮХ	В	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
2013 он /Б-09/											
51	Б.Ганбаатар	Мэргэжилтэн	T3-6	БОХУБ, Мөрөн	В	4	2		Гутгаар	17	Төрийн албанд 5, тухайн албанд 1
52	Б.Билэгдэмбэрэл	Мэргэжилтэн	T3-6	Рашаант	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
53	А.Батболд	Мэргэжилтэн	T3-7	БОАЖГ	В	1.6	1.6	Т/Т	Гутгаар	10	T3-7 ангилал Ахлах түшмэл, нэмэгдэл анхаарах
54	Г.Одгэрэл	Мэргэжилтэн	T3-6	БОХУБ, Цэцэрлэг	А	3	3	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
55	Ч.Мөнхсайхан	МЭҮТ дарга	T3-6	ШинэИдэр	В	3	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1
56	Б.Бат-Амгалан	Мэргэжилтэн	T3-6	БОХУБ, ШИ	А	4	1	Д/Т	Дөтгөөр	15	Төрийн албанд 5, тухайн албанд 1

Зэрэг дэв жил дараалан авсан албан хаагчдын жагсаалт

№	Овог Нэр	Албан тушаалын нэр	Зэрэглэл	Харьяалал	Үр дүнгийн үнэлгээ	Ажилласан жил		Өмнө авсан зэрэг дэв	Одоогийн зэрэг дэв	Зэрэг дэвийн нэмэгдэл
						Төрд	Тухайн албанд			
2009 он										
1	Д.Мөнгөнтуяа	Мэргэжилтэн	T3-5	ХТТ	В	5	5		Дөтгөөр	15
2	Ч.Дашбаяр	Мэргэжилтэн	T3-6	ХТТ	В	4	4		Дөтгөөр	15
3	Г.Гандэлгэр	Мэргэжилтэн	T3-5	ХТТ	В	2	2		Дөтгөөр	15
2010 он										
1	Д.Мөнгөнтуяа	Мэргэжилтэн	T3-5	ХТТ	В	6	2	Дөтгөөр	Гутгаар	17
2	Ч.Дашбаяр	Мэргэжилтэн	T3-6	ХТТ	А	5	2	Дөтгөөр	Дэд	18
3	Г.Гандэлгэр	Мэргэжилтэн	T3-5	ХТТ	В	3	2	Дөтгөөр	Гутгаар	17
4	Б.Мөнхдэлгэр	Байцаагч	T3-6	НДХ	В	15	1		Дөтгөөр	15
5	Н.Таванзул	Байцаагч	T3-5	НДХ	В	1	1		Дөтгөөр	15
2011 он										
1	Б.Мөнхдэлгэр	Байцаагч	T3-6	НДХ	В	16	2	Гутгаар	Дэд	18
2	Н.Таванзул	Байцаагч	T3-5	НДХ	А	2	2	Дөтгөөр	Гутгаар	17
2012 он										
1	Б.Дугараа	Мэргэжилтэн	T3-3	Мөрөн сум	В	4	2		Дөтгөөр	10
2	Б.Мөнхдэлгэр	Байцаагч	T3-6	НДХ	В	16	3	Гутгаар	Дэд	18
3	Б.Цэнд-Аюуш	Сүлжээ зохицуулагч	T3-5	НДХ	В	5	5	Гутгаар	Дэд	18
2013 он										
1	Б.Дугараа	Мэргэжилтэн	T3-3	Мөрөн сум	В	5	5		Дэд	13
2	Б.Мөнхдэлгэр	Байцаагч	T3-6	НДХ	А	17	4	Тэргүүн	Тэргүүн	20
3	Б.Цэнд-Аюуш	Сүлжээ зохицуулагч	T3-6	НДХ	А	6	5	Тэргүүн	Тэргүүн	20

Хавсралт №3
ТАСЗ-өөс ирүүлсэн судалгаа

Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалттай холбоотой түүвэр

Анх орох иргэний нөөц


№	Агуулга	2009	2010	2011	2012	2013
1	Зарласан ажлын байрны тоо	63	74	17	15	27
2	Авсан шалгалтын тоо	2	5	1	1	1
3	Шалгалт өгсөн иргэний тоо	688	382	145	108	494
4	Нөөцөд бүртгэгдсэн иргэний тоо	688	382	145	108	29
5	Үүнээс ажилд орсон иргэдийн тоо	188	74	17	15	10
6	Мөнгөн төлвөрийн дүн	744,4	1446,0	870,0	648,0	

Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалттай холбоотой

Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт

№	Агуулга	2009	2010	2011	2012	2013
1	Зарласан ажлын байрны тоо	14	0	5	5	3
2	Авсан шалгалтын тоо	2	0	1	2	1
3	Шалгалт өгсөн иргэний тоо	55	0	23	103	49
4	Нөөцөд бүртгэгдсэн иргэний тоо	55	0	23	103	49
5	Үүнээс ажилд орсон иргэдийн тоо	12	0	4	5	1
6	Мөнгөн төлвөрийн дүн			240,0	1010,0	282,0

АЙМГИЙН ТАСЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН